



**“ТҮШИГ ИНТЕРНЭШНЛ” ХХК-ИЙН
(ХЭНТИЙ АЙМАГ, БОР-ӨНДӨР СУМ)**

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/ МУ-018936, РД 2714809/

2023 он

ГАРЧИГ

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	14
2.1 Байгаль орчны төлөв байдал.....	14
2.2 Нийгэм эдийн засгийн төлөв байдал.....	15

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	17
3.1 Төслийн гадаад болон дотоод овоолго барьж байгуулах үеийн гол нөлөөлөл.....	20
3.2 Гадаад болон дотоод овоолго байгуулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл	20
3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	21
3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл.....	22
3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл	23
3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл	23
3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл.....	24
3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл.....	24
3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл.....	24
3.11 Хуримтлагдах нөлөөлөл.....	25

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	Error! Bookmark not defined.
--	-------------------------------------

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
ЗУРГАА.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
ДОЛОО. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	38
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	41
ЕС.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	41
АРАВ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	42
АРВАН НЭГ.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	45
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	47
АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	48

АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	50
--	----

ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

<i>Хүснэгт 1. Үйлдвэрийн ажиллах хоног</i>	10
<i>Хүснэгт 2. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа</i>	17
<i>Хүснэгт 3. Гол нөлөөллийн дүн шинжилгээ</i>	18
<i>Хүснэгт 4. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ</i>	21
<i>Хүснэгт 5. Автомашины утааны бүрдэл найрлага</i>	22
<i>Хүснэгт 6. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл</i>	25
<i>Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</i>	29

ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

<i>Зураг 1. Уурхайн гол босоо ам</i>	11
<i>Зураг 2. Бор-Өндөр сумын хил</i>	15
<i>Зураг 3. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарьсан байдал</i>	36

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1	Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	“Түшиг Интернэшнл” ХХК РД: 2714809, ХХД: 9011365136
1.2	Төсөл хэрэгжүүлэгчийн байршил	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 11-р хороо, 85-21 тоот Утас: 99198195

Хоёр. Төслийн талаарх мэдээлэл

2.1	Төслийн нэр	“Хүдрийн биет 16-2” хайлуур жоншны орд
2.2	Төслийн байршил	<ul style="list-style-type: none"> ➤ Тус аж ахуй нэгжийн эзэмшиж буй МҮ-018936 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь нийт 28.07 га бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 310 км, Бор-Өндөр өртөөнөөс 5.0 км-т тус тус байрлана.  <ul style="list-style-type: none"> ➤ Газрын байршил нь олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 6 км-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105 : 2001 стандартын шаардлагыг хангаж байна.

2.3	Төслийн үндэслэл	<ul style="list-style-type: none"> ➤ “Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-өндөр сумын нутаг “Хүдрийн биет 16-2” нэртэй хайлуур жоншны ордыг Ашигт малтмалын газрын МҮ-018936 тоот тусгай зөвшөөрөл нь 2015 оны 06 сарын 22-ний өдрөөс 2045 оны 06-р сарын 22-г дуустал 30 жилийн хугацаатайгаар олгогдсон байна. ➤ Ийнхүү тус “Түшиг интернэшнл” ХХК-ийн “Хүдрийн биет 16-2” нэртэй хайлуур жоншны ордыг ашиглах” төслийн эдийн засгийн үндэслэл”-ийг 2017 онд боловсруулан УУЯ, АМГ-н Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулжээ. ➤ Уурхайн төслүүдийн хувьд ЗГ-н 2012 оны 194-р тогтоолоор батлагдсан “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хамгаалалт бүс болон улсын тусгай хамгаалалттай газрын бүс”-д үйл ажиллагаа явуулахыг хориглодог билээ. Тус компаний эзэмшиж буй МҮ-078936А тоот тусгай зөвшөөрлийн талбай нь дээрх бүсүүдэд давхцалгүй болохыг БОАЖЯ-ны ХБОБНУГ-н даргын 2017-12-05-ны №066/7475 тоот лавлагаагаар тодорхойлов.
2.4	Төслийн зорилго	<p>Тус ордыг хүдэр хоршоолох ашиглалтын системийн аргаар нийт 7.1 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн 210.2 мянган тн хүдрийг жилд дунджаар 30.0 мян.тн буюу 11.5 мян.м³ хүдэр олборлож хайлуур жоншны 92%, 85%, 75% бага агуулга бүхий металлургийн болон бүхэллэг хэсгийн ялган боловсруулж экспортлоно.</p> <p>Тус компанийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хайлуур жоншны ордын талбайн төсөл хэрэгжиж эхэлснээр:</p> <ul style="list-style-type: none"> ➤ 20 хүнийг тогтмол ажлын байр бий болох. /Орон нутгаас 70% хүний нөөц бүрдэх/ ➤ Хайлуур жонш экспортлох үйл ажиллагаа, ачаа тээврийн хурд нэмэгдэнэ. ➤ Орд ашиглалтын хугацаанд улс болон орон нутгийн төсөвд нийт 5 тэрбум 927.0 сая тегрегийг татвар, телбер хураамж хэлбэрээр төвлөрүүлнэ. ➤ Ойролцоох сумдын эдийн засгийн амьжиргаа болон дэд бүтцийн хувьд хувь нэмэр оруулах зэрэг эерэг нөлөө үзүүлнэ.

2.5	Төслийн ерөнхий төлөвлөгөө	<p>Үйлдвэрийн барилга байгууламж буюу 4.271 га талбайд баригдсан барилгууд:</p> <ol style="list-style-type: none"> 1. 8 м өндөр уурхайн цамхаг – төмөр 2ш 2. Өргөх машины барилга – Модон барилга 3. Компрессорын барилга – Сендвичин барилга 4. Уурхайн контор –Сендвичин барилга 5. Ахуй үйлчилгээний барилга – тоосгон 6. Шатах тослох материалын агуулах – 20 м³ –ын ёмкость
2.5	Төслийн хүчин чадал	<ul style="list-style-type: none"> ✚ Тус ордыг хүдэр хоршоолох ашиглалтын системийн аргаар нийт 7.1 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн 210.2 мянган тн хүдрийг жилд дунджаар 30.0 мян.тн буюу 11.5 мян.м3 хүдэр олборлож хайлуур жоншны 92%, 85%, 75% бага агуулга бүхий металлургийн болон бүхэллэг хэсгийн ялган боловсруулж экспортлоно. Хоногийн хүчин чадал $30000:220=136.4$ тн байна. Ээлжинд 45.5 тн, цагт 5.7 тн хүдэр гаргана. ✚ Төслийн багт орон тооны 20 ажилтантай ба 2 ширхэг HOWO байна. ✚ Тус байгууллага нь хүний нөөцийн баг болон техник, технологийн нөөцтэй бөгөөд байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүч, байнг

2.6

Төслийн хог хаягдал

Хатуу хог хаягдал:

Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор нийт 20 ажилтан буюу жилд ажлын 220 хоног ажиллана. Тус төслийн багт 20 хүн ажиллах ба хоногт 1 хүн дунджаар 0,3 кг хатуу хог хаягдал гаргана гэж тооцвол: /жилд ажлын 220хоног/


- хоногт $20 \times 0,3 = 6.0$ кг
- сард $6 \text{ кг} \times 30 \text{ хоног} = 180 \text{ кг}$ буюу 0.18 тн
- жилд $220 \times 180 \text{ кг} = 39\,600 \text{ кг}$ буюу 39.6 тн

Нийт – 39.6 тн/жилд хатуу хог ялгарахаар тооцоолов.

Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгах шаардлагатай.

- ✚ Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт
- ✚ Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд
- ✚ Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна.

Доорхи зургийн дагуу ялгаж хаях шаардлагатай



Шингэн хог хаягдал:

Ахуйн шингэн хог хаягдлын тооцоогоор хоногт нэг ажилтан зөөврөөр хангагддаг тохиолдолд усны нормын дагуу өдөрт 30 литр бөгөөд нийт 20 ажилтан хоногт 2.88 м^3 ус ашиглах ба усалгаанд 6000 м^2 зам талбайг услана гэж үзвэл хоногт 12.0 м^3 , жилд амралт

баяр ёслолын өдрийн хасаад 220 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ $14.88\text{м}^3/\text{хоног}$, үүнээс ахуйн хэрэгцээний 70%-ийг хаягдал ус гэж үзвэл $10.4\text{ м}^3/\text{хон}$ дахин ашиглах болно.

Тиймээс төслөөс гарсан бохир усыг зөөврийн аргаар 5 тонны багтаамж даац бүхий зориулалтын машинаар соруулна. “МҮТТ” ХХК-ийн дотоодод үйлдвэрлэж байгаа бохир ус агуулах 50м³ ын бохирын танк (бохироо соруулах худагт таг, агааржуулалтын хоолойтой сэт) –ыг суурилалтын ажлыг мэргэжлийн компаниар хийлгүүлж, газрын хэвлийд хөлдөлтийн түвшингээс доор 4-5 метрт байгуулж ашиглахыг санал болгов.

Бохир ус агуулах ёнкс ба зөөврийн бохир соруулах машин



Хийн хаягдал:


Төслийн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.

Төслийн ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт **1481.7 тн** /жилд 493.9 тн/ дизель түлш зарцуулахад хөө – 22.96 тн, CO-0.000148 тн, нүүрстөрөгч–0.000445 тн, NO₂–0.00005927 тн, SO₂-0.00002963тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 22.96 тн хорт хий ялгарахаар байна.

/Мэргэжлийн хяналтын агаарын хяналт шинжилгээ хийлгэж байх шаардлагатай./

Аюултай хог хаягдал

Харин тослох материал нь химийн гаралтай шингэн хаягдал болон хөрс бохирдуулагч эх үүсвэр болдог тул ийм төрлийн хаягдлыг өндөр температурт шатааж устгадаг технологийг ашиглан устгах, эсвэл ажилласан тос, аккумулятор болон хаягдал дугуй дахин боловсруулдаг үйлдвэрт /Оргил Баялаг Мандах ХХК/ нийлүүлэхийг зөвлөж байна. */Хавсралтаар хамтран ажиллах гэрээ хавсаргав/.* Ашигласан тос, масло материалыг зориулалтын хамгаалалт бүхий нөөцийн 1 тн-ийн зориулалтын саванд хийж хураан хүргэж өгөх шаардлагатай.

2.7	Ариун цэврийн байгууламж	<p>Төслийн талбайн ажилчдын сэндвичэн байран дотор төвлөрсөн ариун цэврийн байгууламж байгуулах бөгөөд байгаль орчин, ариун цэврийн цаасыг зөв зохистой ашиглах, хувийн ариун цэвэр сахих соёлын тухай санамжуудыг байрлуулах ба экологийн боловсролын булан бий болгосон</p> 						
2.8	Усан хангамж	<ul style="list-style-type: none"> ✚ Төслийн газрын цэвэр усны хангамжийг гүний худгаас хангана. Гэрээт Бор-Өндөрийн худаг нь төслийн байрнаас 5 км зайтай байрладаг бөгөөд эрүүл ахуйн бүсийн шаардлага хангаж байна. ✚ Хүдрийн биетийг хүдрийг үйлдвэрийн аргаар баяжуулахгүйгээр зөвхөн гар аргаар ангилан ялгах чиглэлээр хүдрийг боловсруулж гаргах учраас уурхайд үйлдвэрлэлийн зорилгоор ус бага хэрэглэх бөгөөд зам талбай усалгаанд 12.0 м3/хон усыг уурхайн шүүрлийн уснаас эргүүлэн ашиглах, ахуйн хэрэгцээний усыг гүний худгаас зөөврөөр хангана. /Усны боломжит нөөцийн дүгнэлт болон 2018 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 1/537 тоот албан тоот болон Бор-Өндөр сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Бор Өндөр сумын ус дамжуулах өргөлтийн станцаас ахуйн ундны ус ашиглахыг зөвшөөрсөн албан тоот хавсаргав/ <p>Унд ахуйн зориулалтаар эхний 2 жилд 99.0м3, 3-7 дахь жилд 633.6м3 ус ашиглах тооцоо гарч байна.</p> <table border="1" data-bbox="528 1559 1501 1688"> <thead> <tr> <th>№</th> <th>Уртраг</th> <th>Өргөрөг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Худгийн координат</td> <td>109 24 41.59</td> <td>46 15 39.</td> </tr> </tbody> </table>	№	Уртраг	Өргөрөг	Худгийн координат	109 24 41.59	46 15 39.
№	Уртраг	Өргөрөг						
Худгийн координат	109 24 41.59	46 15 39.						

2.9	Цахилгаан хангамж	<ul style="list-style-type: none"> ➤ Тус бүс нутаг нь эрчим хүчний хувьд сайн хөгжсөн бүсэд оршдог. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумаас Дархан сум хүртэл 35кВт-ын өндөр хүчдэлийн агаарын шугамаар холбогдсон. ➤ “Хүдрийн биет 16-2” жоншны орд нь Бор-Өндөр сумаас Дархан сумдыг холбосон агаарын цахилгаан дамжуулах шугамын 16-р шонгоос агаарын шугам 0.5 км-т татаж ТМН1000/6 трансформаторын дэд станц байгуулан энэ станцаас 500м, 6кВ-ын агаарын шугамыг 2014 онд ашиглалтад өгсөн үүнийг тусгалаа. ➤ Зориулалт бүхий шонгуудыг газарт суулган бэхлэж, цахилгааны утас татах, холболтын ажлыг тусгайлсан зураг гаргаж, мэргэжлийн хүмүүсээр өндөр түвшинд гүйцэтгүүлсэн байна.
2.10	Дулаан хангамж	<ul style="list-style-type: none"> - Тус байгууламж нь ахуйн усны хэрэглээний халаалтад эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем буюу усан бойлерыг хэрэглэнэ. - Өвлийн цагт ажилчдын байр халаалтад нам даралтын зууханд нүүрс ашиглана.
2.11	Гадаад тээвэр	<ul style="list-style-type: none"> ➤ Хайлуур жоншны уурхай нь эцсийн бүтээгдэхүүнээ уурхайгаас 5 км зайд байрлах Бор-Өндөр өртөө хүртэл тээвэрлэнэ. Тус ордын тусгай зөвшөөрлийн талбайгаас Бор-Өндөр хатуу хучилттай зам хүртэл 1.30 км орчим шороон замаар тээвэрлэдэг.



Үйлдвэрлэлийн хүчин чадал

Уурхайн жилийн хүчин чадлыг төслийн даалгаврын дагуу жилд 30000 тн хүдэр олборлон, баяжуулахаар тооцсон болно.

Хоногийн хүчин чадал $30000:220=136.4$ тн байна. Ээлжинд 45.5 тн, цагт 5.7 тн хүдэр гаргана.

Үйлдвэрийн ажиллах горим

Уурхайн хүчин чадал ажиллах хугацааг харгалзан тооцож, жилд ажиллах хоногийг дараах байдлаар тооцож гаргав. Уурхай нь бүтэн жилийн турш хөдөлмөрийн хуулийн дагуу 7 хоногт 5 ажлын өдөр, хоногт 3 ээлжтэй бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг, газрын дээрх ажилчдад 8 цагаар тогтоосон горимоор ажиллана.

Хүснэгт 1. Үйлдвэрийн ажиллах хоног

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Далд уурхайд	Газрын дээр
1	Календарь хоног	хоног	365	365
2	Баяр ёслол	хоног	11	11
3	Амралт	хоног	104	104
4	Засвар үйлчилгээ	хоног	24	24
4	Цаг агаараас хамаарсан сул зогсолт	хоног	6	6
4	Уурхайн цэвэр ажлын хоног	хоног	220	220
5	Хоногийн ээлжийн тоо	-	3	3
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	7	8
7	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0,8	0,8
8	Уурхайн хоногт ажиллах бодит цаг	цаг	16,8	19,2
9	Уурхайн жилд ажиллах бодит цаг	цаг	3696	4224

Уурхайн ашиглалтын хугацаа

Уурхайн ашиглалтын хугацаа нь 7 жил байх ба 1 дэх жилд нь уурхайг байгуулах, нээх 6, 7 дахь жилд нь уурхайн хаалт нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөлөө.

Ордыг нээх ба ашиглах дараалал

Ашигт малтмалын МҮ-018936 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Хүдрийн биет 16-2” нэртэй 28.07 га талбайд өмнөх хайгуулын үед тогтоогдсон (XV шугамаас XVII шугам хүртэлх) хүдрийн биет хамаарагддаг. Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд багтаж буй хүдрийн биет нь газрын гадарга дээр 170 метр урттай 4.55 метрийн дундаж зузаантай 1 хүдрийн биет илэрдэг бөгөөд 1984 оны өрөмдлөг болон бидний малтсан хэвтээ малталтын үр дүнгээс харахад хүдрийн биет нь 1305 метрийн түвшингээс (газрын гадаргаас 26 м-ын гүнд) доош 2 зэрэгцээ хүдрийн биет болон тогтсон байдаг.



Зураг 1. Уурхайн гол босоо ам

2010-2012 онд хайгуулын нөөцийг тодотгох явцад хийсэн шурф малталтыг уурхайн үндсэн босоо ам ствол №1 ба №2 болгон төлөвлөж 70м болон 74 м гүн нэвтэрсэн. Эдгээрээс босоо амнуудад 30м 50м 70м түвшинт хэвтээ нэвтрэлт хийгдсэн. Хүдрийн судлын зүүн баруун хойш чиглэсэн жигүүрийн дагуу хэвтээ малталтыг 100 м нэвтэрч байна.

Ордыг ашиглах дараалал

Ордыг төв хэсэгт нь нээх тул ашиглах дараалал нь төвөөс 2 жигүүр рүү гэсэн байдалтай байна. Блокийг олборлож байх явцад дараа дараагийн бэлтгэл ажлууд хийгдсэн байх ёстой. Блокийг олборлож байхад дараагийн блокуудад хийгдэх ажил нь блокийг бэлтгэх, блокийг нээх ажлууд зэрэг явагдаж байна. Өөрөөр хэлбэл блокийг олборлож дуусахад тасралтгүй буюу цикл ажиллагааг алдагдуулахгүйн үүднээс дараагийн ажил явагдах блок бэлтгэгдсэн байна.

Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

“Хүдрийн биет 16-2” хайлуур жоншны ордын бодит нөөц нь 237.9 мян.тн үүнээс үйлдвэрлэлийн 210.4 мян.тн хүдрийг хоршоолсон системээр блоклон ашиглах боломжтой гэж үзээд техник эдийн засгийн үндэслэлд жилд 30.0 мян.тн хүдэр олборлохоор тусгасан байна.

Баяжуулах хэсэг

Тус талбай дахь хүдрийн биет нь суналын хэмжээнд газрын гадаргууд сайн илэрч гарсан бөгөөд орчин үеийн рельефийн хувьд хэвийн хотгор гүдгэргүй талархуу юм. Хүдрийн биетийн урт-185 м, дундаж зузаан 2.48 м, суналын чиг БХ 337⁰, уналын өнцөг 65⁰-80⁰, гүндээ 140-220 м үргэлжилнэ.

Хүдрийн биетийн геологийн тогтоц болон уул-техникийн нөхцөлүүд нь ордыг далд аргаар хоршоолсон ашиглалтын системээр ашиглахад боломжтойг харуулж байна.

Ашиглалтын системийн сонголт

“Хүдрийн биет 16-2” судал нь “Монголросцветмет” ХХК-ний Бор-Өндөрийн баяжуулах үйлдвэрийн ойролцоо байгаа нь тухайн ордын баяжуулалтын арга технологи, баяжиц зэрэг сайн судлагдсан.

Ийм ч учраас энэ ойр хавийн орд, нэгэн ижил тархацийн энгийн бүтэц бүрэлдэхүүнтэй, дан флюорит юм уу кварц-флюоритын найрлагатай, янз бүрийн настай интрузив, эффүзив, тунамал метасорф чулуулагт хагарлын бүсийг дагасан дүүргэлтийн судлууд голчлон тогтсон байдаг.

“Хүдрийн биет 16-2” биетийн хайлуур жоншны хүдэр дээр 2010 онд Уул уурхайн төсөл судалгааны “Конрес” ХХК лабораторид “Технологийн туршилт” хийлгэсэн.

Хайлуур жоншны хүдэрт агуулагдах CaF₂-ийн агуулга маш өргөн хүрээнд хэлбэлздэг бөгөөд уг агуулгаас нь хамааруулан хүдрийг нь баян (50%-с дээш), дунд зэргийн (35-50%), ердийн (35% хүртэл) гэж ангилдаг. “Хүдрийн биет 16-2” ордын хувьд агуулга дунд зэрэг (40.5%), нөөц багатай бөгөөд хүдрийн бүхэллэгээр нь гараар ялгалт хийн баяжуулах аргыг голчлон сонгон агуулга багатай хүдрээ ойр хавийн флотацийн технологийг ашиглан баяжуулдаг бусад үйлдвэрт зарах боломжтойг харуулж байна.

Гараар ялгах арга: Ашигт эрдэс болон хоосон чулуулгийг өнгө, гялга, хэлбэр дүрсээр нь таньж ялгах процесс юм. Баяжуулалтын бусад аргыг ашиглах боломжгүй нөхцөлд болон баяжмалын чанар шаардлага хангахгүй нөхцөлд уг аргыг ашигладаг. Хамгийн түгээмэл ашиглагддаг төхөөрөмж бол туузан конвейер бөгөөд гараар ялгагч ажилтнууд нэг талаар нь эсвэл 2 талаар нь зогсож ялгалт хийдэг.

Судалгааны үр дүнгээс харахад “Хүдрийн биет 16-2” ордын харьцангуй том ширхэглэлтэй буюу 40мм–ээс дээш ширхэглэлтэй хүдрийг гар аргаар сортлон ялган авч ФК-92, ФК-85, ФК-75 маркийн жоншны баяжмал гарган авах боломжтой .

Баяжуулах технологийн сонголт тооцоо

“Хүдрийн биет 16–2” хайлуур жоншны далд уурхай жилд 30.0 мян.тн жоншны хүдэр олборлон баяжуулах хэсэгт зөөвөрлөнө. Жонш ангилан ялгах хэсэгт хүдрийг шигшүүр дээр +40 мм-ийн хэсгийг ангилан дараа нь гар аргаар ФК-75-с дээш маркийн жоншийг ялгаж таваарын бүтээгдэхүүний овоолго уруу зөөвөрлөн, үлдсэн -40 мм-ийн ангиллын жоншийг -45% агуулгатайгаар баяжуулах үйлдвэрүүдэд нийлүүлэх бага агуулгатай хүдрийн овоолгод овоолно.



Зураг 2. Ялгалт хийж буй хэсэг.

“Хүдрийн биет 16-2” хайлуур жоншны уурхайн хүдэр баяжуулах технологийн схемийг бусад ижил төстэй ордын адил хамгийн тохиромжтой, энгийн арга болох “хүдрийг гараар ялгах технологи”-ийн схемийг сонгосон. Энэ арга нь эрдсийн өнгө, гялтганах шинж чанар, цацраг идэвхт чанар, гэрлийн ойлт зэрэг шинж чанарын ялгаан дээр үндэслэдэг.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Байгаль орчны төлөв байдал

Бор-Өндөр сум нь Хэнтий аймгийн баруун өмнөд хэсэгт: Улаанбаатар хотоос 300 км, Хэнтий аймгийн төвөөс 180 км зайд байрладаг. Өмнөд хэсгээрээ Дорноговь аймгийн Айраг сум, бусад хэсгээрээ Хэнтий аймгийн Дархан сумтай хиллэдэг.

Газарзүйн онцлог: Далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд Монголын дорнод талын их мужийн Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт, Байгалийн бүсийн хувьд хуурай хээрийн бүсэд тус тус багтдаг. Газар хөдлөлийн эрчим 6 балл байна.

Цаг уурын нөхцөл: Хуурайдуу сэрүүн зунтай, хахирдуу өвөлтэй. Жилийн 1 дүгээр сарын дундаж температур -20°C , 7 дугаар сарын дундаж температур $+25^{\circ}\text{C}$, жилийн дундаж салхины хурд 6-8 м/с, жилийн хур тундасны нийлбэр 150-200 мм. Уур амьсгал: Хуурай хээрийн, цөлөрхөг говь хээрийн уур амьсгал зонхилно. Дулаан зунтай чийг дутмаг мужид багтана. Бүх нутгаар агаарын хэмийн харьцангуй жигд тархалттай байдаг. Ургамшил тачирхан, чулуурхаг буюу элсэрхэг гадаргатай тул наранд халж агаарын хэмийг дээшлүүлдэг. Хамгийн их хүйтрэл 1-р сард, хамгийн их халуун 7-р сард болдог. Агаарын температурын сарын дундаж нь бүх нутгаар 8-13 градус байдаг ба олон жилийн дунджаар 1,5 градусаар дулаан байна. Жилд дунджаар 200 орчим мм тунадас унадаг. Нутгийн ноёлох салхи баруун хойноосоо ихэвчлэн салхилдаг ба хамгийн их салхи шуургатай үе 3, 4, 5-р сар юм.

Хөрсний шинж чанар: Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт тархсан хөрсийг шинж чанар газарзүйн байршил хөрс үүсгэгч нөхцөлөөр нь: 1. Долгирхог тал, хээрийн ба өргөн хөндийн хөрс 2. Голын хөндийн, нугын хээршсэн хөрс 3. Уулархаг, уулын хөрс 4. Хээрийн элсэрхэг, хүрэн хөрс гэж хуваана. Долгиорхог хээр талын ба өргөн хөндийн хөрс зонхилох хувийг эзлэнэ. Ховор тохиолдох нуур тойрмын зах хэсгээр хужир марзтай хөрс тохиолддог. Түр зуурын ус тогтдог хотгоруудад шаварлаг хөрс үүссэн байна. Хуурай сайрын хөндий болон тэгш талд элсэрхэг хөрс тархсан байна.

Ургамал зүйн байдал: Цахилдаг, алаг өвст, хиаг-хялганат, бужмаг, хонгорзул, улалж, бут бударгана, харгана, халгай, буурцагт өвсний төрөл зонхилно. Үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс болон амт чанар, шимт сайтай үетэн, буурцагт, алаг өвсний төрлийн ургамал зонхилно. Мөн гол, булаг, нуур тойрмын хөвөөгөөр хиаг, хазаар өвс, салхин ерхөг, дэрс, харгана, адамсын агь, хэрс зэрэг ургамал ургадаг ба сумын урд говирхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботуульт ургамал зонхилон ургадаг байна. Нам доор хотгор газруудаар дэрс, хааяа тохиолдох булгийн дэргэд зэгс, сухай, бургас ургана.



Ан амьтан: Бор-Өндөр сум нь 77 мянган тоо толгой таван хошуу малтай, уул хадаараа 30 гаруй аргаль янгир бэлчдэг, цагаан зээр бэлчээрлэдэг, цаашдаа тарвага нутагшуулах зорилготой байна.




Түүхийн дурсгалт газрууд: Бор-Өндөр сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт түүхийн дурсгалт газрууд оршдог. Эртний булш бунхан, хэргэсүүр байдаг. Олон овоот, зугаалгын хад, хүслийн мод, Далантүрүү рашаан, Агуйт зэрэг олон сайхан байгалийн үзэсгэлэнт газар байдаг.

2.2 Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Хэнтий аймгийн Бор-Өндөр сум нь 1981 онд Хэрлэн хороо гэж байгуулагдаж, газар нутгийн харъяалал нь хуучнаар Хэнтий аймгийн Дархан сумын 5-р баг байсан. УИХ-ын 2012 оны 02 сарын 09 ний өдрийн 15-р тогтоолоор Бор-Өндөр сум болон өөрчлөгдөж, 2012 оны 12 дугаар сараас эхлэн сумын бүтэц зохион байгуулалтад орсон. 1-р баг /Бор-Өндөр/, 2-р баг /Холбоо/, 3-р баг /Бумбат/, 4-р баг /Уурхайчин/, 5-р баг /Хүйх/, 6-р баг /Өлгий/ гэсэн 6 багийн нийт 2660 өрх, 8883 хүн амтай. Хүн амын тоогоор Хэнтий аймгийн 18 сумаас эхнээсээ 1-д, газар нутгийн хэмжээгээр 18-д ордог /аймгийн төвийг оролцуулалгүйгээр/ хүн амын нягтралаар хамгийн өндөр 60,99 хүн/га сум юм.

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах МҮ-018936 “Хүдрийн биет 16–2” хайлуур жоншны далд уурхай төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Газар нутгийн хэмжээ -14400 га


Зориулалт	Хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Уул уурхайн зориулалттай газар	9500	67,8
Ойн сан бүхий газар	0	0
Усан сан бүхий газар	0	0
Тусгай хэрэгцээний газар	0	0
Тосгон, суурингийн газар	3000	21,5
Дэд бүтцийн газар	1500	10,7

Хүн ам, өрхийн тоо


Үзүүлэлт	Хүн амын тоо
Хүн амын тоо	
Нийт эрэгтэй	4442
0-4 нас	534
5-9 нас	520
10-14 нас	334
15-19 нас	404
20-24 нас	393
25-29 нас	399
30-34 нас	391
35-39 нас	351
40-44 нас	290
45-49 нас	253
50-54 нас	236
55-59 нас	160
60-65 нас	80
65-аас дээш нас	97

Малын тоо ангилал, сүүлийн 5 жилээр графикаар

Сумын хэмжээнд 2017 оны байдлаар нийт 77,014 мянган мал тоологдсон.



Сумын малын тоог сүүлийн 5 жилээр графикаар харууллаа:



ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 2. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа

Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Сөрөг Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
Нэг. Төслийн үйл ажиллагааны явцад				
Шатах тослох материал, ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх	Гүний ус, ургамал	Төслийн талбай, туул голын ус	Бага	Төсөл хэрэгжих хугацаанд

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах МҮ-018936 “Хүдрийн биет 16–2” хайлуур жоншны далд уурхай төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Зам, жим харгуй ихсэх	Агаар, хөрс, амьтан,	Авто зам түүний ойр орчим	Дунд	Төсөл хэрэгжих хугацаанд
Олборлолтон д өртөх	Газрын хэвлий	Төслийн талбай	Дунд	Төсөл хэрэгжих хугацаанд

Хүснэгт 3. Гол нөлөөллийн дүн шинжилгээ

Нөлөөллийн ангилал	Гол нөлөөлөл	Нөлөөллийн цар хүрээ	Нөлөөллийн эрчим	Нөлөөллийн үргэлжлэх хугацаа
<p>1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> • Бохирдуулах <p>• Эвдэх</p> <ul style="list-style-type: none"> • Доройтуулах 	<ul style="list-style-type: none"> • Санамсаргүй алдаа гарсан тохиодолд автомашины тос алдаж хөрс, шороо бохирддог. • Хөрс эвдэх нөлөөлөлд уурхайн хөрсийг дураараа сэндийчих, барилга өргөтгөн барих ажлууд хамаарагдаж байна. • Доройтуулах нөлөөлөлд автомашины хүн тээврийн маршрут, хог хаягдлын төвлөрсөн цэгийг хашаалаагүй зэрэг хамаарагдаж байна. 	Төслийн эдэлбэр газрын хэмжээ	<p>Хөрс бохирдуулах нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.</p> <p>Хөрс эвдэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.</p> <p>Хөрс доройтуулах нөлөөллийн эрчим дунд зэрэг эрчимтэй байна.</p>	Төсөл хэрэгжих хугацаанд
2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл	Үйл ажиллагааны явцад гүний усыг бохирдуулах нөлөөлөл нь ШТМ асгарах зэрэг орно.		Газрын гүний усны нөөцийг бууруулах нөлөөллийн	Төсөл хэрэгжих хугацаанд

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах МҮ-018936 “Хүдрийн биет 16–2” хайлуур жоншны далд уурхай төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

<ul style="list-style-type: none"> • Бохирдуулах • Нөөцийг бууруулах 	Газрын гүний ус ашигладаг учраас нөөцөд бага зэрэг нөлөөлнө.		эрчим их байна.	
<p>3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> • Амьдрах орчинг хуваах • Амьдрах орчинг доройтуулах • Амьдрах орчинг хомсдуулах • Нөөцийг бууруулах 	Хүнд даацын хөдөлгөөн нь тэдгээрийн амьдрах орчныг хуваах, доройтуулах, хомсдуулах нөлөөллийг үзүүлж байна.	Төслийн эдэлбэр газрын хэмжээ	Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
<p>4. Агаарт үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> • Бохирдуулах • Тоос 	Галлагааны зуухаас угаар, автомашины шатаасан хийн угаар нь агаарыг бохирдуулж түүний чанарыг доройтуулдаг. Замын барилгын ажил нь агаарт тоос дэгдээж сөрөг нөлөө үзүүлдэг.	Төслийн эдэлбэр газрын хэмжээ	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд зэргийн эрчимтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
<p>5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс</p> <ul style="list-style-type: none"> • Хамгаалах • Нүүлгэн шилжүүлэх 	-	-	-	-

Эндээс үзэхэд тус төслийн эдэлбэр газар төдийгүй орчны газар нутгийг хамгаалалтад авч, авто хөсгийг зөвхөн тогтоосон замаар явуулж, үйлчлүүлэгчдийн тоог тогтоосон норм хэмжээнээс давуулахгүй байхыг үл харгалзваас хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамал нөмрөгийг алдралд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдож, ургацын хэмжээ буурч, экологийн тэнцвэрт байдал алдагдахад дөхөм үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх нөлөөллийн хүчин зүйлүүдээс хамгийн их нь хүнд даацын автомашины хөл хөдөлгөөн ихсэх, төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр холхиж олон

салаа зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал асгарах нь хөрс, усны бохирдол, ургамлан нөмрөг алдралд орон хомсдож биомассын хэмжээ багасах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах бүлэгт өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хэрэгжүүлж, цаашид байгаль хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байх шаардлагатай.

3.1 Төслийн гадаад болон дотоод овоолго барьж байгуулах үеийн гол нөлөөлөл

- Гадаад болон дотоод овоолгыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, кемпийг барих явцад хөрс, ургамал механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах
- Будаг, маажин, цавуу мэтийн химийн бодис асгарснаас хөрс ургамал, хөрсний ус, голын ус бохирдох, амьд организм хордох
- Нунтаг болон цементийн зуурмаг, шохой асгаж, модны зомгол, золтос, үйрдэс, шилний хагархай зэрэг элдэв төрлийн хог хаягдлаар орчныг бохирдуулах
- Төслийн талбайн хөрс, ургамал бүхэлдээ эвдрэл, элэгдэлд орно.

3.2 Гадаад болон дотоод овоолго байгуулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл

- Объектын орчин тойронд хөрс, ургамлан нөмрөг элэгдэл, эвдрэлд орох
- Зам жим, барилга байгууламжийн орчны хөрс талхлагдах, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, үйлчлүүлэгчдийн тоо олширсноор голын эрэг бохирдох
- Автомашины хөдөлгөөн нэмэгдсэнээс агаар орчин бохирдох зэргээр илэрнэ.

Төслийн байгууламжийг барих эхний үе шатанд объектыг байгуулах, газар шорооны ажил гүйцэтгэхэд тухайн орчны хөрс, ургамал нэн түрүүнд өртөж, суваг шуудуу татах зэрэгт рельефийн зарим хэлбэрийн үндсэн төрх алдагдах, шинээр бичил хэлбэр бий болж, газрын хөрсний механик бүтэц, ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орно. Ийм тохиолдолд тухайн байгууламж барих хэсгийн өнгөн хөрсийг хуулж овоолго хийж нөхөн сэргээлт болон цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах нь зүйтэй. Нөхөн сэргээхдээ төсөлд тусгасан зураг төслийн дагуу тухайн орчинд зохицсон ургамал тарих шаардлагатай. Овоолго барих үеийн нөлөөллийн төрөл нэлээд олон байгаа хэдий ч хамрах хүрээ нь бага, эрчим нь их байна. Иймд байгууламжийг барьж дууссаны дараа нөхөн сэргээх ажлыг яаралтай хийх шаардлагатай. Ашиглалт жигдэрсний дараа орчинд үзүүлэх нөлөөллүүд нь түүний олон талт үйл ажиллагаатай уялдан хүрээгээ тэлэх магадлалтай байгаа нь ажиглагдаж байна.

Тус төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бүхий л хүрээнд авч үзвэл: хөрс дагтарших, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, голын ус болон эрэг бохирдох, хөрсний усаар дамжин гүний ус бохирдох, биомассын хэмжээ багасах, элдэв төрлийн бохирдлоос амьтан, ургамал ялангуяа хөрсөн дэх бичил биетэн, хорхой шавьж хордож устах, мөлхөгч, мэрэгчид, жигүүртэн шувууд дайжих, мод бут өвс ургамал механик гэмтэлд өртөх гэж үзэв.

Эдгээр сөрөг нөлөөлөл нь нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, байгаль

орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан асуудлуудад хайхрамжгүй хандсанаас үүсч болно. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг дараах бүлэгт дэлгэрэнгүй оруулсан бөгөөд тус зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгч цаашид мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих орчимд агаарын бохирдол харьцангуй бага байна гэж үзэж байна. Энэ нутгийн агаар, ус, хөрс, ургамал байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан бөгөөд ялангуяа уг төсөл хэрэгжих талбай нь хүний суурьшилын бүсээс зайтай, тухайн орчимд агаар орчинд хүчтэй нөлөөлж бохирдуулах эх үүсвэр байхгүй учир тухайн төсөл хэрэгжих талбайн агаар нь харьцангуй цэвэр ба төслийн үйл ажиллагаанаас суурьшлын бүсэд үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байна.

Төсөл хэрэгжих орчмын агаарын бохирдлын эх үүсвэр нь барилга байгууламж барих явцад үүсэх тоосжилт, барилгажилтанд ажиллах машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ зэрэг болно.

Мөн агаарын бохирдлын гол үүсвэрийн нэг нь байгалийн хүчин зүйл болох шороон шуурга гэж болно. Чухам ийм үед л тоос, шороо ихээр дэгдэж агаар орчныг бохирдуулна.

Цаашид уурхайн тээврийн хэрэгслийн ирж очих машин механизмуудын түлшний шаталтаас үүсэх хорт хий, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын чанарт хими болон физикийн тодорхой нөлөөллийг бага хэмжээгээр үзүүлэх болно.

Дээрх нөлөөллийн хэлбэрийг доор дурдсан байдлаар ялган төсөөлж болох юм. Үүнд:

☞ Ургамалын бүрхүүл, бэлчээр тоос шороонд дарагдах

☞ Агаар дахь тоосны агууламж ихсэн хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлөх

Иймд төсөл хэрэгжих орчин нь уул уурхайн бүс гэдгийг харгалзан үзэж хүний үйл ажилагаанаас үүдэлтэй тоосны сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга зам, хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлох нь нэн чухал юм.

Тээвэрлэлтийн /уурхайн олборлолтын/ үед эвдэрсэн газрыг тухай бүр нөхөн сэргээх, аль болохоор олон салаа зам гаргахгүй байх, автомашин зорчих гол замыг цаашдаа хатуу хучилттай болгох зэрэг бололцоотой бүхий л арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

Хийн хаягдлаас үүсэх гол сөрөг нөлөөлөл

Автомашин утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310г, дизель хөдөлгүүр 80-100г хорт бодис ялгаруулна. 1кг шатахууныг литрт шилжүүлэн (бензин $q=0.725$, дизель $q=0.825$) бодож, түүний шаталтаас ялгаран гарах хорт хийн агуулалт, хэмжээг тооцоолон гаргасан. Автомашин утааны агаарыг бохирдуулах чанарыг тодорхойлохдоо бензин хөдөлгүүрт бол нүүрстөрөгчийн ба азотын ислийн агууламжийг, дизель хөдөлгүүрт бол хөө тортогийн агууламжийг үндсэн үзүүлэлт болгодог.

Хүснэгт 4. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ

Бохирдол	Автомашин асаалттай, сул зогсолттой байх үед	Машин хурдтай явж байх үед (60 км/цагаас дээш)	Машин тойргоор эргэх үед	Машины хурд саарч байх үед (60 км/цагаас доош)
СО (%)	4 – 9	< 1 – 8	1 – 7	2 – 9
НС, С ₆ Н ₁₄ (ppm)	500 – 1000	50 – 80	200 – 800	3000 – 12 000
NO _x (ppm)	10 – 50	1000 - 4000	1000- 3000	5 – 50

Дээрх хоёр төрлийн хөдөлгүүрийн утааны дундаж найрлагыг дараах хүснэгтэд харуулав. Энэ нь байгаль орчинд цацагдаж байгаа утааны техникийн болон мониторингийн хяналтын үзүүлэлт, ашиглагдах ач холбогдол юм.

Хүснэгт 5. Автомашины утааны бүрдэл найрлага

№	Бүрдэл	Хөдөлгүүрийн төрөл		Тайлбар
		Бензин	Дизель	
1	Азот (%)	74-77	76-78	Хоргүй
2	Хүчилтөрөгч (%)	0.3-8	2-18	Хоргүй
3	Усны уур (%)	3-5.5	0.5-4	Хоргүй
4	Нүүрсхүчлийн хий (%)	5-12	1-10	Хоргүй
5	Нүүрстөрөгчийн исэл (%)	1-10	0.01-0.5	Хортой
6	Азотын исэл (%)	0.1-0.5	0.001-0.4	Хортой
7	Альдегид (%)	0.0-0.2	0-0.009	Хортой
8	Нүүрс-устөрөгчид (%)	0.01-0.02	0.01-0.5	Хортой
9	Хүхэрлэг хий (%)	0-0.002	0-0.03	Хортой
10	Хөө тортог (г/м ³)	0-0.44	0.01-1.1	Хортой
11	Бенз (а) пирен (г/м ³)	<0.00002	<0.00001	Хортой

Хүснэгтээс харахад, 1л бензин шатаахад ялгарах хорт бодисын хэмжээ нь дизель түлшнийхээс дунджаар 3.1 дахин их байгаа бөгөөд зөрүүгийн хэмжээ нь 3-4 хооронд хэлбэлзэж байдгийг судалгаагаар тогтоосон байна.

3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Уг төсөл хэрэгжих талбай нь байгалийн хүчин зүйлс болох ус, салхины нөлөө, мөн хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр газрын гадарга болон хэвлийн их хэмжээний эвдрэлтэй, ихэнх хэсэг харьцангуй унаган төрхөө хадгалсан, хэсэг газар ургамал хөрс талхлагдаж, ухмал нүх үүссэн, одоогийн байдлаар бага зэрэг хог хаягдалтай байна.

Тус төсөл хэрэгжихэд нийт талбайн 31% буюу 15.0 га талбайн гадаргуу өртөгдөж байгаль орчинд сөрөг нөлөө учруулна.

Төслийн олборлолтын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Газрын хэвлий ухах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнээс үүдэн хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг

устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, үүний улмаас элсэнцэр хөрс салхинд хийсэх, элсжилт үүсэх

- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр газрын гадарга, хэвлий бохирдох
- Болзошгүй тохиолдлоор гал алдах, түймэр гарах

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх шаардлагатай.

3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газар нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс-био уур амьсгалын Хангайн мужийн өндрийн бүсшил бүхий Хангай-Хэнтийн өмнөдийн хэв шинж бүхий 52 дугаар тойрогт хамрагдана. Энд уулын бэлээр нугын, уулын хойд хажуугаар уулын ширэгт-тайгын, уулын хар шороон, уулын ойн бараан, уулын хар шороон, уулын хар хүрэн хөрснүүд тус тус тархана.

Төслийн үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй нөлөөллүүдийг жагсаан үзүүлбэл:

Төслийн өргөтгөл барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Байгууламжийн материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, төсөл хэрэгжих явцад хөрс, ургамал, мод бут механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах гэх мэт орно.

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.

3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбай болон түүний орчмын газар нутаг нь Монгол орны байгалийн мужлалаар ойт хээрийн бүсэд багтана.

Уулын ойт хээрт хамаарах ихэнх нутагт жилдээ 300-400 мм, Хангай, Хэнтий, Монгол-Алтайн нурууны захын салбар уулсаар жилдээ 200-300 мм тунадас унадаг, ургамал ургах хугацааны хувьд тогтмол дулаарсан (+5⁰С-ээс дээш) 132-150 (145) хоног үргэлжилдэг юм. Гэвч уулсаараа ургамал ургах хугацаанд зожир хүйтрэлтэй байдаг. Сүүлчийн цочир хүйтрэлт ихэнхдээ 6-р сарын дундуур, эхний цочир хүйтрэлт 8-р сарын дундуур ажиглагдана. Цаг уурын олон жилийн дунджаас үзэхэд ихэнхдээ хавар, намартаа түр зуурын гандуу үе илэрнэ.

Уурхайн олборлолт болон төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр /тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг/ зүйлийн бүрдлийн хэвийн байдалд өөрчлөлт гарч, орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдаж, тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төсөл орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдах,
- Тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно. /Хогийн ургамал/
- Төсөл орчмын мод бут механик гэмтэлд өртөх

3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбай орчмын нутаг нь монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар Хэнтийн тойрогт багтана. Хэнтийн тайгын голлох элемент болох олон зүйлийн хөхтөн амьтдын тархалттай.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр бичил биетэн устах, хордох
- Төслийн олборлолтын ажлын үеийн тэсрэлт болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дуу чимээ зэргээс тухайн орчны амьтад үргэн дайжиж амьтны аймагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл

Гадаргын болон гүний усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдэд, бичил бохир цэвэрлэх байгууламжаас гарсан цэвэршүүлсэн усыг тоосжилт болон ногоон байгууламжийн усалгаа зэрэгт эргүүлэн ашиглах, үер болохоос сэргийлж далан байгуулах, голын ойр орчимд ахуйн болон үйлдвэрийн бохирдлоос сэргийлэх хамгаалалтын төлөвлөгөө, анхааруулга сэрэмжлүүлэг бүхий самбар, мөн гүний ус ашиглалтыг хянах, хэрэглээг багасгах, гүний усны цооног болон гүний худгийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг багтана.

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газар доорх усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсний ус болон борооны усаар дамжуулан гол горхи бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын гол горхины ус ба түүний эргийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Голын усны горим хүний үйл ажиллагааны нөлөөгөөр урсацын горимын үйл ажиллагаа алдагдах

3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Уул уурхайн үйл ажиллагаа нь улс орон нутгийн төсөвт багагүй орлого оруулах, зуны улиралд ажлын цөөнгүй байр гардаг нь ажилгүйдлийг багасгах, хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх чухал хүчин зүйл болж байна. Тухайн орон нутгийн

экологийн чадавхаас хэтэрсэн ажил үйлчилгээ эрхлэх хэт олон том жижиг уурхай байгуулж хүн амын төвлөрөл бий болгох хөл хөдөлгөөн ихэсгэхээс аль болохоор зайлсхийх, бүс нутгийн дүрэм журмын дагуу зохих хязгаарлалт хийх нь зайлшгүй шаардлагатай бөгөөд нэгэнт байгуулагдсан болон байгуулах гэж буй уурхай нь байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамгийн бага хэмжээнд хүртэл нь бууруулах талаар туйлын хариуцлагатай хандаж идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь чухал юм.

Төслийн олборлолтын ажлын тоос болон дуу чимээний нөлөө нь ойролцоо оршин суугч иргэдэд нөлөөлөл үзүүлэх болно. Оршин суугч иргэдийн ашигладаг худгийн ойролцоо гүний усыг ашигласнаар бага гүний усны түвшин буурч энэ нь ойролцоох өрхүүдэд шууд нөлөөлж болзошгүй. Төслийн байгууламжийн ойр зорчих тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр зам тээврийн осол үүсгэхэд нөлөөлж болзошгүй.

3.11 Хуримтлагдах нөлөөлөл

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн хайлуур жоншны орд төсөл нь Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт хэрэгжиж байгаа бөгөөд тухайн бүс нутагт уул уурхайн орд газруудын үйл ажиллагаа явагддаг ба төслүүдийн зүгээс хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засагт эерэг болон сөрөг нөлөөг тодорхой хэмжээгээр үзүүлэх юм. Үүнээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь энэ төслийн сөрөг нөлөөтэй уялдан газар ашиглалт, хөрсний бохирдол, хөрсний талхагдал, агаарын чанар, ан амьтны дайжилт, ургамлан нөмрөг доройтох зэргээр хуримтлагдах нөлөөллийг үзүүлнэ. Иймд эдгээр хуримтлагдах нөлөөллөөс өөрийн нөлөөллийн байдлыг ялган салгахын тулд нөлөөллийн бүсэд тогтоосон БОМТ-г цаг тухай бүрд нь авч хэрэгжүүлж, тайлагнах нь зүйтэй.

Төсөл хэрэгжих явцад уурхайн олборлолт, төслийн цаашдын үйл ажиллагааны явцад тухайн төслийн үйл ажиллагаа болон орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй, богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэж болзошгүй.

Хүснэгт 6. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл

№	Хуримтлагдах нөлөөлөл	Нөлөөллийн шалтгаан	Хамрах цар хүрээ	Үргэлжлэх хугацаа
1	Газрын гадарга ба хэвлий эвдрэлд өртөх	Бусад төслүүдийн нөлөөлөл	Төслийн талбай, нөлөөллийн бүс	Өнгөрсөн, одоо, ирээдүй
2	Газрын доорх усны нөөц багасах	Бусад төслүүдийн усны хэрэглээ, хэрэглээний давхцал		Одоо, ирээдүй
3	Гадаргын ус бохирдох	Бусад төслүүдийн нөлөөлөл		Өнгөрсөн, одоо, ирээдүй
4	Ургамлан нөмрөгийн доройтол	Уур амьсгалын өөрчлөлт, төслийн үйл ажиллагаа		Өнгөрсөн, одоо, ирээдүй
5	Агаарын бохирдол нэмэгдэх	Хуурайшилт, бусад төслүүдийн бохирдол		Өнгөрсөн, одоо, ирээдүй

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах МҮ-018936 “Хүдрийн биет 16–2” хайлуур жоншны далд уурхай төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

6	Хөрсний бохирдол, элэгдэл үүсэх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй
7	Амьтан дайжих, тоо толгой цөөрөх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй


Хуримтлагдах нөлөөлөл, түүний үр дагаварыг бодитой тодорхойлох, эрт хугацаанд илрүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны тодорхой үе шат хэрэгжсэний дараа төслийн үйл ажиллагаанд мониторинг хийхийг зөвлөж байна.

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	60 431 000 төг
	2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	10 000 000 төг
	3. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	10 000 000 төг
	4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	20 000 000 төг
	5. Түүх соёлын өв хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
	6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	2 000 000
	7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	5 676 000 төг
	8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	-
	9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	12 400 000 төг
	10. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	355 000 төг

МАНАЙ КОМПАНИ НЬ 2023 ОНД НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

1. 2023 оны Бор-Өндөр сумын баяр наадамд 4 сая төгрөг хандивласан.
2. Хан Хэнтий уул аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баяр наадамд 10 сая төгрөг хандивласан.
3. Хэнтий аймгийн Хурлын даргын нэрэмжит Ахмадуудын аймгийн аварга шалгаруулах 4-р их наадамд зориулж Бор-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 1,500,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
4. Хэнтий аймагт зохион байгуулагдах “Эрдэнэт сүргийн эзэд” малчдын чуулга уулзалтанд 2 сая төгрөгийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн.
5. Мөн Бор-Өндөр сумандаа үер ус, цасан шуурганаас үүдэлтэй зам саатсан үед техник тоног төхөөрөмжийн туслалцааг байнга үзүүлж байдаг.
6. Мөн Бор-өндөр сумын Засаг даргын тушаалаар “Нийтийн их цэвэрлэгээ”-нд тогтмол оролцож.Өөрсдийн эзэмшлийн талбайн гадуурх болон 6-р багийн нутаг дэвсгэрт заасан газарт өөрсдийн техник, хүн хүчийг дайчлан цэвэрлэгээ үйлчилгээнд тогтмол оролцдог.



**БОР-ӨНДӨР СУМЫН
БАЯР НААДМЫН КОМИСС**
23185 Бор-Өндөр сум, Бор-Өндөр 1 баг
Утас: 88887811, 7056-7488

2023.07.05 № 02
танай _____-ны № _____-т

“ТҮШИГ ИНТЕРНЭШНЛ” ХХК-Д


Жил бүрийн сумын баяр наадмын бай шагналд дэмжлэг туслалцаа үзүүлдэг танд болон танай хамт олонд талархал илэрхийлье.

Энэ жилийн Бор-Өндөр сумын баяр наадам 2023 оны 07 сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулагдана.

Иймд нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана уу.

Хүндэтгэсэн:

ДАРГА



Х.ГАЛБАДРАХ

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Түшиг интернэшнл” ХХК-ийн хайлуур жоншны ордын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлтийн үр дүн
1	Агаар орчин	Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөн ихэссэнээс агаар бохирдуулах, ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэж болно.	Хог хаягдлын савыг ангилах, битүү саванд хийх, бохирыг соруулах	Жилд 1 удаа дууны түвшин хэмжигч NL-04 багажаар хэмжилтийг хийсэн. Уулын ажлын үед дуу чимээ дунд зэрэг, ажлын өдрүүдээр бага зэрэг болно. Тоосжилтын эсрэг байнга усалгаа хийх, ногоон байгууламж байгуулах зэрэг ажил явагдлаа. Уурхайн талбай дотор 50ширхэг.
	Усны нөөц, чанар	Газрын доорх усыг авч ашигласанаар газрын доорх урсацын горим алдагдах, усны бохирдол, шатах		


2		<p>тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамжилтад сөргөөр нөлөөлж болзошгүй.</p>	<p>Нүхэн жорлонг устгаж соруулдаг сайжруулсан жорлон байгуулах</p>		<p>Эко соруулдаг 00-г стандартын дагуу барьж байгуулав</p>
---	--	---	--	--	--



3			<p>Төсөл хэрэгжих эзэмшил болон хариуцан хамгаалах талбайг хаврын шар усны үерийн болон гадаргын усны урсацаас хамгаалах зорилгоор шуудуй байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах</p>		
---	--	--	--	--	--

4			<p>Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах -Spill kit авч байршуулах HSCT LLC</p>	<p>Тэсрэх бодисын агуулах болон ШТМ хадгалдаг газруудад урьдчилан сэргийлэх үүднээс асгаралтын иж бүрдэл байршуулсан.</p>	
5			<p>Тусгай зөвшөөрлийн дагуу ашигт малтмал болон газар ашигалх гэрээний дагуу газрын төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах</p>	<p>Газрын төлбөр төлсөн баримтыг хавсаргав.</p>	
6	<p>Хөрс, ургамал, амьтны аймаг</p>	<p>Хөрс болон ургамал нөмрөг хүн, мал, техникийн нөлөөгөөр устах, сийрэгжих, улмаар энэ нь ургамал нөмрөг их хэмжээгээр алдралд орох эх үүсвэр болж болно. Хөхтөн, шувууд зэрэг амьтдыг дуу</p>	<p>Мал амьтан машин техникт дайруулж үхэж үрэгдэхээс сэргийлж уурхайн нутаг дэвсгэр болон уурхайн ойр орчимд 3-аас доошгүй тэмдэг тэмдэглэгээг байршуулах</p>	<p>Мал амьтан машин техникт дайруулж үхэж үрэгдэхээс сэргийлж уурхайн нутаг дэвсгэр болон уурхайн ойр орчимд 3-аас доошгүй тэмдэг тэмдэглэгээг байршуулсан, мөн уурхайн нийт ажилчидад "Амьтны тухай хууль"-д заасан тарвага, зээр агнах тухай болон тэдгээртэй холбоотой "Зөрчлийн тухай хууль"-н талаарх сургалт орсон.</p>	

ГГХ-14	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх	ХХЦСТХ-7.2.4	Нотолгоо ГГХ-7	Н	4352.18 га талбай бүхий газарт мод тарьж зүлэгжүүлэх шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэгч Ажилчдын кэмпиин орчим тарьсан мод бут хэвийн байна. Цаашид нэмэгдүүлэн мод тарих шаардлагатай
ГГХ-15	Тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох	ХХЦСТХ-7.2.5	Нотолгоо ГГХ-8	Н	
ГГХ-16	Олон салаа зам гаргахгүй байх	ХХЦСТХ-6.1.6	Нотолгоо ГГХ-9	Н	
ГГХ-17	Ой болон ургамлыг хамгаалах, ойжуулах	ХХЦСТХ-6.2.4	Нотолгоо ГГХ-7	Н	

8. УСАН ОРЧНЫ АУДИТ

8.1. Аудитын зорилго:

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төсөл нь унд ахуйн усны хэрэглээг 1 гүний худгаас хангадаг. Уурхайн олборлолтын үед шүүрлээр ус алдагддаг. Шүүрлийн усыг зам талбайн тоосжилт дарахад ашигладаг. Мөн бохирын нэгдсэн системд холбогдоогүй учраас бохир усыг шууд хөрсөнд зайлуулж байна. Усны менежментийн аудит нь эдгээр процессыг хамруулан гүйцэтгэгдсэн болно.

8.2. Аудитын хамрах хүрээ:

Цаг хугацааны хувьд:

Тус төслийн 2021, 2022 оны хоорондох үйл ажиллагаанд байгаль орчны аудитын ажлыг гүйцэтгэнэ.

Оронзайн хувьд:

- ~ Бохирын цооног
- ~ Усны хэрэглээ
- ~ Шүүрлийн ус

Хууль тогтоомжийн хүрээнд:

Хууль эрхзүйн баримт бичиг	Батлагдсан огноо	Шийдвэрийн дугаар	Хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон огноо
Төрийн бодлого, үндэсний хөтөлбөр			
Алсын хараа 2050 баримт бичиг	2020.05.13	МУИХ-ын 52 тоот	
Шинэ сэргэлтийн бодлого	2021.12.30	МУИХ-ын 106 тоот	
Монгол улсын хууль			
Усны тухай хууль	2012.05.17		2019.05.02
Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	2012.05.17		2019.05.02
Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай	2009.07.16		2015.12.04
Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал	2009.07.16		2015.02.18

хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай			
Монгол улсын дүрэм, журам			
Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам	2018.12.26	МУЗГ-ын 391-р тогтоол	
Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам	2013.05.16	БОНХ-ын сайдын А156	
Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам	2015.06.05	БОНХАЖ/БХБ-ын сайдын А230/127	
Ус бохирдуулсаны төлбөрийн хэмжээ		МУЗГ-ын 316-р тогтоол	
Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам	2015.03.30	МУЗГ-ын 120-р тогтоол	
Стандарт			
Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015	2015.12.24	СҮЗ-ийн 50-р тогтоол	
Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010	2010.09.30	СҮЗ-ийн 24-р тогтоол	

8.3. Аудитын шалгуур:

Дээр дурдсан хууль тогтоомжийн хүрээнд 28 шалгуур үзүүлэлтээр усан орчны аудитыг гүйцэтгэв. Нийт 12 шалгуур нь үндэсний хууль тогтоомж, стандартад, 16 шалгуур нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус тус тусгалаа олсон байна.

8.4. Баталгаажсан нотолгоо:

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгох бөгөөд нийт 12 нотолгоог аудитын явцад цуглуулав. Үүнээс бичиг баримтын судалгааны явцад 9, газар дээрх аудитын явцад 3 нотолгоог бүрдүүлсэн. Нийт нотолгоог ангилан авч үзвэл:

~ Тэмдэглэл	... ширхэг
~ Баримт бичиг	9 ширхэг
~ Дуут бичлэг	... ширхэг
~ Дүрс бичлэг	... ширхэг

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

~ Асуулгын хуудас	... ширхэг
~ Ярилцлага	... ширхэг
~ Байршил	... ширхэг
~ Фото зураг	3 ширхэг
~ Лабораторийн шинжилгээ	... ширхэг
~ Судалгааны үр дүн	... ширхэг багтана.

8.5. Аудитын үнэлэмж:

Нийт 28 шалгуурыг 12 нотолгоон дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

- Нийцэл	26
- Тодорхойгүй	...
- Хугацаа болоогүй	...
- Үл нийцэл	2

8.6. Үл нийцлийн эрсдэл:

Усан орчны аудитаар дараах 2 үл нийцэл илэрсэн болно. Эдгээрийг хэрэгжүүлэхгүй нөхцөлд үүсэх эрсдэлийг үр дагаварт суурилсан эрсдэлийн матрицын аргаар үнэлэсэн болно.

		Байгаль орчны хохирол үүсэх магадлал		
		Гарцаагүй	Боломжтой	Боломж бага
Байгаль орчны нөлөөллийн	Их	У-15		
	Дунд		У-5	
	Бага			

Дээрх үр дүнгээс үзэхэд 1 үл нийцэл нь эрсдэл ихтэй, 1 үл нийцэл нь эрсдэл дунд, ангилалд хамаарч байна. Эрсдэлийн түвшин бүрээс хамааруулан дараах зөвлөмжийг өгч байна.

8.7. Зөвлөмж:

Зөвлөмж У-5: Ус ашиглалтын холбогдох мэдээ тайланг төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгч байх шаардлагатай.

Зөвлөмж У-15: Шүүрлийн усыг шууд байгальд нь нийлүүлж байгаа нь усны тухай хуулийн 30.5-р зүйлийг зөрчиж байна. Иймд усны тухай хуулийн 21-р зүйлд заасан усны мэргэжлийн байгууллагатай хамтран шүүрлийн усны алдагдлыг хязгаарлах, ашиглах боломжийг судлах шаардлагатай.

8.8. Аудитын дүгнэлт:

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн усны нөөц, ус ашиглалт, усны чанар зэрэг чиглэлээр төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, үндэсний хууль тогтоомж, холбогдох дүрэм журам, аргачлал, стандартын хүрээнд нийцлийн болон гүйцэтгэлийн байгаль орчны аудит хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ үл нийцсэн шалгуурт мэргэжлийн зөвлөмж боловсрууллаа.

- “Түшиг Интернэшнл” ХХК-ийн “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн үйл ажиллагаа нь дээр дурьдсан хууль эрхзүйн баримт бичигт нийцэл 92.85 хувь, үл нийцэл 7.15 хувьтай байна.
- “Түшиг Интернэшнл” ХХК -ийн дээрх үл нийцлээр үнэлэгдсэн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг биелүүлэх зайлшгүй шаардлагатай.

Хүснэгт 5. Усны менежментийн аудитын хүснэгт

№	Аудитын шалгуур үзүүлэлт	Эрхзүйн үндэслэл	Баримт нотолгоо	Үнэлэмж	Тайлбар, тэмдэглэл
У-1	Ус, рашааны нөөц, чанар, найрлагыг тогтоосон хайгуул, судалгааны тайлан, ашиглах боломжит нөөцийн талаарх дүгнэлт	УТХ-28.2.2	Нотолгоо У-1	Н	
У-2	Хоногт 100 шоомтрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.	УТХ-26.1 болон 28.4	Нотолгоо У-2	Н	
У-3	Усны тухай хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоомтрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоо метр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоомтрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ	УТХ-28.6	Нотолгоо У-3	Н	
У-4	Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтоож Монгол улсын усны тухай хуулийн 22.4-д заасан дэглэмжийг мөрдөж ажиллана.	БХТХ-19.2.6, УТХ-22.1, 22.4 БОНХАЖЯ, БХБ сайдын 2015 оны А-230/127 тоот тушаал	Нотолгоо У-4	Н	Усан сан бүхий газар байхгүй. Ус хангамжийн худгийн эрүүл ахуйн дэглэмийг мөрдөж ажиллаж байна. Эрүүл ахуйн бүсийг хамруулан хашаа татаж, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулах хэрэгтэй.
У-5	Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан сав газрын захиргаанд гаргаж өгөх үүрэгтэй.	УТХ-7.5, БОНХ-ын сайдын А-86 тоот тушаал		ҮН	Ус ашиглалтын холбогдох мэдээ тайланг төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгч байх шаардлагатай.

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

У-6	Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоомтрээс их, эсхүл энэ хуулийн 10.1.12-д заасан аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа, хоногт 50 шоомтрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно.	УТХ-24.2	Нотолгоо У-6	Н	
У-7	Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон журмын дагуу ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулсан байна.	УТХ-24.4 БОАЖ-ын сайд, ЭМ-ын сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам	Нотолгоо У-5	Н	
У-8	Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх	УТХ-30.1.1	Нотолгоо У-6	Н	
У-9	Хоногт 50 шоомтрээс их ус ашиглагч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.7-д заасны дагуу дотоод хяналтын цэг, техник хэрэгсэлтэй байх ба усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах;	УТХ-30.1.2	Нотолгоо А-1	Н	Тус уурхай нь байгаль орчны мэргэжилтэнтэй. Тус мэргэжилтэн уурхайн хатуу, шингэн хийн хаягдал, дотоод хяналтыг хэрэгжүүлдэг.
У-10	Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх, эсхүл шууд зайлуулах	УТХ-30.1.3	Нотолгоо У-7	Н	Гэрээ дагуу шууд зайлуулж байна.
У-11	Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах;	УТХ-30.1.4	Нотолгоо У-6	Н	
У-12	Ус, рашааны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлөх	УТХ-30.1.5, УБТТХ, ЗГ-ын 316-р тогтоол	Нотолгоо У-8	Н	

9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АУДИТ

9.1. Аудитын зорилго:

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын менежментийн чиглэлд байгаль орчны аудит хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ үл нийцсэн шалгуурт мэргэжлийн зөвлөмж боловсруулах зорилготой.

9.2. Аудитын хамрах хүрээ:

Цаг хугацааны хувьд:

Тус төслийн 2021, 2022 оны хоорондох үйл ажиллагаанд байгаль орчны аудитын ажлыг гүйцэтгэнэ.

Оронзайн хувьд:

- ~ Ажилчдын кэмп.
- ~ Засварын төв.
- ~ Хог хаягдлын цэгүүд

Хууль тогтоомжийн хүрээнд:

Хог хаягдлын тухай хууль Монгол Улсын Их хурлын 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан бөгөөд мөн хуулийн дагаж дараах дүрэм журам батлагдсан байна.

- ✓ Монгол улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 116 тоот тогтоол “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүтгэх, тайлагнах, Аюултай хог хаягдлын ангилалын жагсаалт”
- ✓ Монгол улсын БОАЖ-ын сайдын 2018 оны 11 дугаар сарын 19-ний өдрийн А/445-р тушаал “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар”
- ✓ Монгол улсын БОАЖ-ын сайдын 2018 оны 11 дугаар сарын 17-ний өдрийн А/443-р тушаал “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”
- ✓ Монгол улсын БОАЖ-ын сайдын 2018 оны 11 дугаар сарын 12-ний өдрийн А/428-р тушаал “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
- ✓ Монгол улсын БОАЖ-ын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн А/349-р тушаал “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн ангилал”

- ✓ Монгол улсын БОАЖ-ын сайдын 2018 оны 11 дугаар сарын 13-ний өдрийн А-429/257-р тушаал “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт”
- ✓ Монгол улсын БОАЖ-ын сайдын 2018 оны 01 дугаар сарын 30-ний өдрийн А/18-р тушаал “Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам”
- ✓ Монгол улсын БОАЖ-ын сайдын 2018 оны 04 дугаар сарын 05-ний өдрийн А/82/128-р тушаал “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам”

9.3. Аудитын шалгуур:

Дээр дурдсан хууль тогтоомжийн хүрээнд 27 шалгуур үзүүлэлтээр хог хаягдлын менежментийн аудитыг гүйцэтгэв. Нийт 27 шалгуур нь бүгд үндэсний хууль тогтоомж, дүрэм, журамд тусгалаа олсон байна

9.4. Баталгаажсан нотолгоо:

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгох бөгөөд нийт 8 нотолгоог аудитын явцад цуглуулав. Үүнээс бичиг баримтын судалгааны явцад 5, газар дээрх аудитын явцад 3 нотолгоог бүрдүүлсэн. Нийт нотолгоог ангилан авч үзвэл:

~ Тэмдэглэл	... ширхэг
~ Баримт бичиг	5 ширхэг
~ Дуут бичлэг	... ширхэг
~ Дүрс бичлэг	... ширхэг
~ Асуулгын хуудас	... ширхэг
~ Ярилцлага	... ширхэг
~ Байршил	... ширхэг
~ Фото зураг	3 ширхэг
~ Лабораторийн шинжилгээ	... ширхэг
~ Судалгааны үр дүн	... ширхэг багтана.

9.5. Аудитын үнэлэмж:

Нийт 27 шалгуурыг 8 нотолгоон дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

~ Нийцэл	15
~ Тодорхойгүй	2
~ Хугацаа болоогүй	1
~ Үл нийцэл	9

9.6. Үл нийцлийн эрсдэл:

Хог хаягдлын менежментийн аудитаар дараах 10 үл нийцэл илэрсэн болно. Эдгээрийг хэрэгжүүлэхгүй нөхцөлд үүсэх эрсдэлийг үр дагаварт суурилсан эрсдэлийн матрицын аргаар үнэлэсэн болно.

		Байгаль орчны хохирол үүсэх магадлал		
		Гарцаагүй	Боломжтой	Боломж бага
Байгаль орчны нөлөөллийн түвшин	Их		XX4, XX14, XX17, XX21, XX23	
	Дунд		XX3, XX11	
	Бага			XX1, XX18

Дээрх үр дүнгээс үзэхэд 2 үл нийцэл нь эрсдэл бага, 2 үл нийцэл нь эрсдэл дунд, 5 үл нийцэл нь эрсдэл өндөр гэсэн ангилалд хамаарч байна. Эрсдэлийн түвшин бүрээс хамааруулан дараах зөвлөмжийг өгч байна.

9.7. Зөвлөмж:

Зөвлөмж ХХ-1: БОАЖЯ-ны сайдын 2018 оны А/428 тоот тушаалын дагуу хог хаягдлын талаарх мэдээ тайланг орон нутаг дахь холбогдох нэгжид гаргаж өгөх

Зөвлөмж ХХ3: Байгууллага ажилтан бүрт хог хаягдлыг ангилан ялгах, 5R зарчмын талаар сургалтыг жил бүр зохион байгуулж байх шаардлагатай.

Зөвлөмж ХХ4: Энгийн хог хаягдлыг ахуйн болон бусад гэж ангилах зориулалт бүхий хогын цэгтэй боловч ангилан ялахгүй байна. Тодорхой цэгүүдэд ангилан ялгах боломжтой хогийн савнууд байршуулах, сургалт зохион байгуулах замаар ажилчдыг хог хаягдлыг ангилан хаях соёлд сургах хэрэгтэй.

Зөвлөмж ХХ11: Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэхэд 2 кэмгийн тохиромжтой байршилд 4 ангилах боломжтой хогийн савнууд байршуулах, сургалт зохион байгуулах, дотоод журамд тусгаж өдөр бүр сануулж байх хэрэгтэй.

Зөвлөмж ХХ14: Хог хаягдлыг бууруулах арга замыг судлах, хэрэгжүүлэх ажлын зохион байгуулах шаардлагатай.

Зөвлөмж ХХ17: 1. Хог хаягдал аль болох үүсгэхгүй байх; 2. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх, эрэлхийлэх зорилгоор 5R аргыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх 3. Шинэ санаа, санаачлага, арга, технологи гаргах, нэвтрүүлэх талаар дотоод журмандаа тусгах /шинэ санаа, санаачлага гаргасан бол урамшуулах зохицуулалт хэрэглэж болно 5. Хог хаягдал ангилан ялгах ажлыг ногоон буюу байгаль орчинд ээлтэй сэтгэлгээгээр хийж, хэрэгжүүлэх;

Зөвлөмж ХХ21: ХХТХ-23.3 болон АХХТХЦТДБУБТЖ-2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.4, 2.2.5, 2.2.6, 2.2.7 зэрэгт заасан шаарлагын дагуу өөрийн талбайд үүсэх аюултай хог хаягдлыг хадгалах шаардлагатай.

Зөвлөмж ХХ23: Үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах, эргүүлэн ашиглах, хоргүйжүүлэх, устгах чиглэлээр ажилчидаас гарсан санал санаачлагыг дэмжих, урамшуулах, зарим хог хаягдлыг (дугуй, хоол хүнсний хаягдал, зарим бүтээгдэхүүний сав баглаа боодлыг нийлүүлэгч талд буцаан нийлүүлэх гэх мэт) дахин ашиглах, хэмжээг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

9.8. Аудитын дүгнэлт:

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн хог хаягдлын менежментийн чиглэлээр төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, үндэсний хууль тогтоомж, холбогдох дүрэм журам, аргачлал, стандартын хүрээнд нийцлийн болон гүйцэтгэлийн байгаль орчны аудит хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ үл нийцсэн шалгуурт мэргэжлийн зөвлөмж боловсрууллаа.

- “Түшиг Интернэшнл” ХХК -ийн “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн үйл ажиллагаа нь дээр дурьдсан хууль эрхзүйн баримт бичигт нийцэл 62.5 хувь, үл нийцэл нь 37.5 хувьтай байна.
- “Түшиг Интернэшнл” ХХК -ийн дээрх үл нийцэл болон тодорхойгүйгээр үнэлэгдсэн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг биелүүлэх зайлшгүй шаардлагатай.

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн аудит

№	Аудитын шалгуур үзүүлэлт	Эрхзүйн үндэслэл	Баримт нотолгоо	Үнэлэмж	Тайлбар, тэмдэглэл
Монгол улсын хууль эрхзүйн баримт бичиг					
ХХМ-1	Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах төхөөрөмжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад өгөх	БОХТХ-31.3		ҮН	БОАЖЯ-ны сайдын 2018 оны А/428 тоот тушаалын дагуу хог хаягдлын талаарх мэдээ тайланг гаргаж өгөх
ХХМ-2	Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх	ХХТХ-10.2.17	Нотолгоо А-1	Н	

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

XXM-3	Хог хаягдлын талаархи сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх	ХХТХ-10.2.12, 10.2.16		ҮН	
XXM-4	Энгийн хог хаягдлаа ангилан ялгах	ХХТХ-10.2.1 ЭХХАЦТДБСАУ БҮАТЭС-2.2		ҮН	Энгийн хог хаягдлыг ахуйн болон бусад гэж ангилах зориулалт бүхий хогын цэгтэй боловч ангилан ялахгүй байна. Тодорхой цэгүүдэд ангилан ялгах боломжтой хогийн савнууд байршуулах, сургалт зохион байгуулах замаар ажилчдыг хог хаягдлыг ангилан хаях соёлд сургах хэрэгтэй.
XXM-5	Шаардлага хангасан хогийн савтай байх - хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн; - галд тэсвэртэй материалаар хийгдсэн; хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.	ХХТХ-10.2.2, 15.1.1, 15.1.2, 15.1.3	Нотолгоо ХХ-1	Н	Хог хаягдлын цэгийг дараах байдлаар сайржуулах хэрэгтэй. - Хүнсний, дахин ашиглах боломжтой, боломжгүй, бусад гэж ангилах боломжтой байхаар - Хуртунадасны ус хуримтлагдах, шүүрэл явагдахаас сэргийлж хатуу хучилттай байх
XXM-6	Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах	ХХТХ-10.2.3	Нотолгоо ХХ-2	Н	
XXM-7	Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх	ХХТХ-10.2.4		ҮН	Хог хаягдлыг хуваарийн дагуу нэгдсэн хогийн цэгийн 70%-тай тэнцэх үед нь ачуулж байх шаардлагатай.
XXM-8	Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх	ХХТХ-10.2.5	Нотолгоо ХХ-4	Н	
XXM-9	Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох	ХХТХ-10.2.6	Ярилцлага	Н	
XXM-10	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх	ХХТХ-10.2.7	Нотолгоо ХХ-3	Н	
XXM-11	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх	ХХТХ-10.2.8		ҮН	

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

XXM-12	Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх	ХХТХ-10.2.9	Хээрийн ажиглалт	Н	
XXM-13	Хог хаягдлын тухай хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх	ХХТХ-10.2.10	Хээрийн ажиглалт	Н	
XXM-14	Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах	ХХТХ-10.2.13		ҮН	Хог хаягдлыг бууруулах арга замыг судлах, хэрэгжүүлэх ажлын зохион байгуулах шаардлагатай.
XXM-15	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой Хог хаягдлын тухай хуулийн 10.3-т заасан үйл ажиллагааг явуулахыг хориглоно хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях; - нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях; - хог хаягдлыг ил задгай шатаах; - гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах; - хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях; - аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах; - нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.	ХХТХ-10.3	Хээрийн ажиглалт	Н	
XXM-16	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, бүлшлэх үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлын мэдээг батлагдсан маягтын дагуу сум дүүрэгт, аюултай хог хаягдлын мэдээг аймаг, нийслэлд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	ХХТХ-11.3		ҮН	
XXM-17	Хог хаягдал үүсгэгч этгээд анхдагч эх үүсвэр дээр хог хаягдал үүсгэхдээ болон эрх бүхий этгээд эрхлэх үйл ажиллагааны явцад БОАЖЯ-ны сайдын 2018 оны А/443 тоот журмын 1.6-т заасан зарчмыг баримтлах	БОАЖЯ-ны сайдын 2018 оны А/443 тоот журмын 1.6		ҮН	1. Хог хаягдал аль болох үүсгэхгүй байх; 2. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх, эрэлхийлэх зорилгоор 5R аргыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх 3. Шинэ санаа, санаачлага, арга, технологи гаргах, нэвтрүүлэх талаар дотоод журмандаа

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

					тусгах /шинэ санаа, санаачлага гаргасан бол урамшуулах зохицуулалт хэрэглэж болно/ 4. Хог хаягдал ангилан ялгах ажлыг ногоон буюу байгаль орчинд ээлтэй сэтгэлгээгээр хийж, хэрэгжүүлэх;
XXM-18	Аюултай хог хаягдал үүсгэгч нь ХХТХ-д заасны дагуу бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байна.	ХХТХ-21.1, ЗГ-116 тогтоол-6.1		ҮН	Тус уурхайн төслийн үйл ажиллагаанаас 13 нэр төрлийн аюултай хог хаягдал гарч байгаа учир аюултай хог хаягдлын үүсгэгчээр орон нутгийн холбогдох газарт бүртгүүлж, бүртгэлийн дугаар авах шаардлагатай.
XXM-19	Хог хаягдлын тухай хуульд заасан хугацаанд аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах	ХХТХ-23.1		ТБ	Хог хаягдлын тухай хуулийн 23.3-т заасны дагуу хадгалаж эхлэсэн хугацааг тэмдэглээгүй учир хэзээ үүссэн нь тодорхой бус байна. Иймд тодорхой бус ангилалд оруулав.
XXM-20	Тодорхой шалтгааны улмаас энэ хуулийн 23.1-д заасан хугацаанаас илүү хугацаагаар хадгалах бол аймаг, нийслэлийн хог хаягдлын менежментийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, түр хадгалах зөвшөөрөл авна.	ХХТХ-23.2		ТБ	Аюултай хог хаягдлыг хог хаягдлын тухай хуулийн 23.1-д заасан хугацаанаас илүү хугацаагаар хадгалах бол Хэнтий аймгийн хог хаягдлын асуудал эрхлэсэн алба, хэлтэст мэдэгдэж зөвшөөрөл авах шаардлагатай.

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

XXM-21	<p>Аюултай хог хаягдлыг дараах шаардлагыг хангасан нөхцөлд түр хадгална.</p> <ul style="list-style-type: none"> - Агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална. - аюултай хог хаягдлыг ангилан ялгасан байх - аюултай хог хаягдлыг агуулах сав нь агуулж буй хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийгдсэн, эсхүл ийм материалаар доторлосон байх - аюултай хог хаягдлыг хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн нэр, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх бөгөөд ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байх - хог хаягдлын аюулын шинж чанар болон аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулсан байх - үүсэх хог хаягдлын төрөл, кодыг хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх; - гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангасан байх - шаардлагатай газруудад дараах мэдээллийг нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна. (аюултай хог хаягдал хариуцсан ажилтны овог нэр, утасны дугаар, гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материалын байрлалыг заасан зураг, схем, галын дуудлага өгөх утасны дугаар) 	ХХТХ-23.3 болон АХХТХЦТДБУБТЖ-2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.4, 2.2.5, 2.2.6, 2.2.7		ҮН	ХХТХ-23.3 болон АХХТХЦТДБУБТЖ-2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.4, 2.2.5, 2.2.6, 2.2.7 зэрэгт заасан шаарлагын дагуу өөрийн талбай үүсэх аюултай хог хаягдлыг хадгалах шаардлагатай.
XXM-22	Аюултай хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих	ХХТХ-2.3.1	Нотолгоо ХХ-5	Н	Аюултай хог хаягдал нь голлон засварын төвөөс гарч байна. Эдгээр хог хаягдлыг ангилан ялгаж өөрийн талбай дээр хадгалаж байна. Ийнхүү хадгалаж байгаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд эрсдэлтэй хэдий ч зарим хог хаягдлыг

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

					тусгайлан бэлтгэсэн талбайд хадгалаж байгаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаагийн нэгэн жишээ юм. Цаашид хог хаягдлыг зориулалтын шаардлага хангасан нөхцөл, хугацаанд хадгалах хэрэгтэй.
XXM-23	Үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах, эргүүлэн ашиглах, хоргүйжүүлэх, устгах замаар байгаль орчинд ялгарах ялгарал, бохирдуулагчийн хэмжээг бууруулах	ХХТХ-2.3.2		ҮН	Үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах, эргүүлэн ашиглах, хоргүйжүүлэх, устгах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил байхгүй байна.
XXM-24	Өөрийн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлаа устгах тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авах	ХХТХ-2.3.3		ХБ	Талбай дээр үүссэн хог хаягдлыг устгах чиглэлээр арга хэмжээ аваагүй байна.
XXM-25	Өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаа устгах болон дахин боловсруулах боломжгүй тохиолдолд аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, экспортлох зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх	ХХТХ-2.3.4	Нотолгоо ХХ-6	Н	
XXM-26	Хэвийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдалтай харьцах болон аюул ослын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцдаг ажилтан бүрээр боловсруулж, тэднийг сургаж, дадлагажуулах	ХХТХ-2.3.5	Нотолгоо ХХ-7 Нотолгоо ГГХ-10	Н	
XXM-27	Анхны тусламж үзүүлэх зааварчилгаа боловсруулж, шаардлагатай материал, хэрэгслээр хангах.	ХХТХ-2.3.6	Нотолгоо ХХ-7	Н	
XXM-28	Аюултай хог хаягдал хариуцсан ажилтан нь аюул осол гарсан, аюултай хог хаягдал асгарсан, алдагдсан тохиолдолд арга хэмжээг АХХТХЦТДБУБТ журмын 2.5-т заасан арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авна. <ul style="list-style-type: none"> - галын дуудлага өгөх, гал тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, боломжтой бол унтраагуур, хэрэгсэл ашиглаж галыг унтраах - асгарсан аюултай хог хаягдлын асгаралтыг зогсоох, тархалтаас сэргийлэх арга хэмжээ авах, бохирдсон материал, хөрсийг цэвэрлэх - хүний эрүүл мэндэд аюул учруулахуйц галын аюул, дэлбэрэлт, асгаралт 	АХХТХЦТДБУБТЖ-2.5	Нотолгоо ХХ-7 Нотолгоо ГГХ-10	Н	

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

үүссэн, гадаргын усыг бохирдуулсан тохиолдолд тухайн орон нутгийн онцгой байдлын болон мэргэжлийн хяналтын байгууллагад яаралтай мэдэгдэж, дараах мэдээллийг өгнө.

10. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Төв аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн байгаль орчны аудитыг нийт 103 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд нийцэл 84, үл нийцэл 14, үлдэх нь хугацаа болоогүй ангилалд хамаарна. Нийт дүнгийн арифметик дунджаар тус төслийн үйл ажиллагааний нийцэл 81.5 % буюу төслийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2023/A-142
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Түшиг интернэшнл" ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2023.08.02
Дээжийн тодорхойлолт : уурхайн газар
Шинжилгээний аргын стандарт : MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021
CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2023.08.02
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт Тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	N46°15'33.63", E109°24'36.29"	VIII/2	12:05	0.009	0.021	0.140	40
2	N46°15'62.97", E109°24'03.37"	VIII/2	12:45	0.010	0.025	0.120	44
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Д.Түмэндэлгэр

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН
ЗАСАГ ДАРГА**

Бор-Өндөр баг, Бор-Өндөр сум, Хэнтий аймаг, 23220

Утас: (976) 70567143

Цахим шуудан: borundur_khentii@yahoo.com

2024.01.02 № 01

танай _____-ны № _____-т

Тодорхойлолт


БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Өлгий 6 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Түшиг-Интернэшнл" ХХК-ны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дүйцүүлэн хамгаалах чиглэлээр 1.9 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн солбилцлыг хүргүүлэв.

1. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн солбилцол.

1. 46 16 50.17 109 26 33.43	2. 46 16 51.90 109 26 38.87
3. 46 16 48.92 109 26 43.94	4. 46 16 48.48 109 26 49.18
5. 46 16 46.86 109 26 48.37	6. 46 16 47.71 109 26 42.32
7. 46 16 49.37 109 26 38.33	8. 46 16 48.86 109 26 34.50

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ




Х.ГАЛБАДРАХ

Бор-Өндөр сум

Түшиг-Интернэшнл ХХК

Legend

 1.9 га дүйцүүлэн хамгаалах



Google Earth

Image © 2023 CNES / Airbus

200 m



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: ТҮШИГ ИНТЕРНЕЙШНЛ ХХК

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,
ТОО

Ус, 1

ЗАХИАЛГА №: 2023/979

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2023.06.21

ШИНЖИЛСЭН ОГНОО: 2023.07.03

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй

ХУУДАСНЫ ТОО: 1

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна.
Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

Чанарын менежер:



Д.Пүрэвжаргал

Хамтран ажилласан таньд талархлаа.


ЗАХИАЛГА №: 2023/979

ДЭЭЖИЙН ДУГААР: 1

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-12140


№	ЭЛЕМЕНТ	НЭГЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 0900:2018/	СТАНДАРТ АРГА
1	pH	-	7.75	6.5-8.5	MNS ISO 10523:2001
2	Кали (K ⁺)	мг/л	1.10	-	MNS 5465:2005
3	Натри (Na ⁺)	мг/л	30.29	200.0	
4	Кальци (Ca ²⁺)	мг/л	61.91	100.0	MNS ISO 2572:1999
5	Магни (Mg ²⁺)	мг/л	16.30	30.00	
6	Аммони, (NH ₄ ⁺)	мг/л	<0.10	1.50	MNS ISO 7150-1:2006
7	Хлорид, (Cl)	мг/л	27.23	350.0	MNS ISO 9297:2005
8	Сульфат (SO ₄ ²⁻)	мг/л	63.60	500.0	MNS 3652.4:1984 MNS ISO 11885:2011
9	Нитрит (NO ₂ ⁻)	мг/л	<0.05	1.00	MNS 4431:2005
10	Нитрат, (NO ₃ ⁻)	мг/л	1.88	50.00	MNS ISO 7890-3:2001
11	Карбонат (CO ₃ ²⁻)	мг/л	3.00	-	MNS ISO 9963-1:2005
12	Гидрокарбонат (HCO ₃ ²⁻)	мг/л	204.4	-	
13	Нийт хатуулаг	мг-экв/л	4.43	7.00	
14	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	334.0	1000	MNS 4423:1997
15	Цахиурын хүчил, H ₂ SiO ₃	мг/л	25.29	-	
16	Исэлдэх чадвар /KMnO ₄ /	мгO ₂ /л	1.44	-	MNS ISO 4889:1999
17	Фосфат, PO ₄ ³⁻	мг/л	<0.05	3.5	MNS ISO 6878:2001
18	Фтор, F	мг/л	0.28	0.7-1.5	MNS ISO 10359-1:2002
19	Хүхэргүстөрөгч, H ₂ S	мг/л	<0.10	0.1	
20	Чөлөөт хлорид, Cl _{чөл}	мг/л	<0.10	0.2-0.3	MNS ISO 7393-1:2001
21	Булингар	NTU	<10.0	1.5	
22	Мөнгө, Ag	мг/л	<0.01	0.1	
23	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	0.50	
24	Мышьяк, As	мг/л	<0.01	0.01	
25	Бор, B	мг/л	0.04	2.40	
26	Бари, Ba	мг/л	<0.01	0.70	
27	Берелли, Be	мг/л	<0.001	0.0002	
28	Кадми, Cd	мг/л	<0.005	0.003	
29	Кобальт, Co	мг/л	<0.001	-	
30	Хром, Cr	мг/л	<0.005	0.05	
31	Зэс, Cu	мг/л	<0.02	2.0	
32	Төмөр, Fe	мг/л	<0.03	0.3	MNS (ISO) 11885:2011
33	Марганец, Mn	мг/л	<0.01	0.1	
34	Молибден, Mo	мг/л	<0.005	0.07	
35	Никель, Ni	мг/л	<0.005	0.02	
36	Хартугалга, Pb	мг/л	<0.01	0.01	
37	Сурьма, Sb	мг/л	<0.01	0.02	
38	Селен, Se	мг/л	<0.05	0.04	
39	Стронци, Sr	мг/л	0.46	2.00	
40	Уран, U	мг/л	<0.10	0.03	
41	Цайр, Zn	мг/л	<0.01	5.0	
42	Цианид, CN _{free}	мг/л	<0.002	0.01	MNS ISO 6703(II):2005
43	Мөнгөн ус, Hg	мг/л	<0.001	0.001	EPA Method 7473

Шинжээчийн дүгнэлт: Шинжилгээнд ирүүлсэн усны чанар - Монгол улсад мөрдөгдөж буй "Ундны усны MNS 0900:2018 стандарт"-ын шаардлагыг хангаж байна.





“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/08-04/2

Захиалагч: “Төгрөг баянхангай” ХХК

Дээж авсан цэг: Түшиг Интернэшнл ХХК, Хэнтий аймаг, Хайлуур жоншны орд, агуулах

Сорьц авсан огноо: 2023 оны 08 сар 01 өдөр

Шинжилгээ хийсэн огноо: 08 сарын 04

Харилцах утас:



1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	рН	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO ₃ , %	NO ₃ , мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
Зүсэлт 1											
1	0-20	7.84	0.038	0.090	2.35	0.0	0.24	21	9	1.5	12
Зүсэлт 2											
2	0-20	7.46	0.094	0.222	2.04	0.0	0.32	19	8	1.3	15

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Зүсэлт 1								
1	0-20	25.9	51.5	3.5	8.2	3.2	7.7	19.1
Зүсэлт 2								
2	0-20	20.8	52.0	7.4	9.1	3.3	7.4	19.8

* Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна





3. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Зүсэлт 1	0-20	54.5	30.6	0.0	128.2	60.0	17.8
Зүсэлт 2	0-20	59.7	27.8	0.0	124.8	46.3	13.4
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

**Харгалзах түвшин * Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна*

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Хүнд металлуудыг - хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН:  Х.УУГАНЦЭЦЭГ, Д.ЭНХЧИМЭГ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:  Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор



Нарт ШУҮН Консалтинг ХХК

Уул уурхайн олборлолт, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас

1. Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: "Түшиг интернэйшнл" ХХК-ны 2023 оны БОМТөлөвлөгөөний биелэлт
2. Төслийн байршил: Хэнтий аймаг Бор-Өндөр сум
3. Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-018936
4. Огноо: 2023.12.06.

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо									Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар
			Г.Мөнх-Эрдэнэ	Ө.Маналжав	Б.Мөнхжаргал	Ц.Батбуян	Н.Солонго	Б.Баярбаясгалан	Х.Галбадрах	Б.Мөнх-Оргил	Т.Эрдэнэзаяа		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	16	16	16	16	16	16	16	16	16	16	5 ажил төлөвлөснөөс 4 ажил гүйцэтгэсэн.
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/	30	-	-	-	-	-	-	-	-	-	30	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдаагүй
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	1.5 га талбайд дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт төлөвлөсөн. 1.9 га техникийн нөхөн сэргээлт хийгдсэн
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	1 ажил төлөвлөсөн 1 ажил гүйцэтгэсэн.
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	-	-	-	-	-	-	-	-	-	5	Тухайн жилд холбогдох асуудлаар ямар нэгэн ажил төлөвлөөгүй.

6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	6.7	6.7	6.7	6.7	6.7	6.7	6.7	6.7	6.7	6.7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгаснаас хийгдсэн. 3 ажил 2 ажил
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд төлөвлөгдсөнөөс гүйцэтгэсэн. 3 ажил 3 ажил
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.5	2.5	Агаарын шинжилгээг 1 цэгт 1 удаа төлөвлөснөөс хийгдсэн. Хөрсний шинжилгээг 1 удаа хийхээс 1 удаа хийсэн. Усны шинжилгээг 2 цэгээс жилд 1 удаа хийхээр төлөвлөснөөс 2 цэгээс 1 удаа авсан. Дүгнэлт гаргуулаагүй.
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	1 ажил төлөвлөсөн. 1 ажил гүйцэтгэсэн.
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөнд 1 ажил төлөвлөж 1 ажил хийгдсэн.
	Нийт оноо	100	90.2	90.2	90.2	90.2	90.2	90.2	90.2	90.2	90.2	90.2	Биелэлт хангасан

Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт биелэлтээс нь хамааран авсан байвал зохих оноог тогтоосон ба ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны энгийн арифметик дунджийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тооцож гаргана. Гишүүдийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн онооны энгийн арифметик дунджийн нийлбэр нь нийт оноо болно. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн нийт оноо нь 90-аас доош байвал төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж үзнэ. Тухайн жилд дүйцүүлэн хамгаалах ажил төлөвлөгдөөгүй бол нөхөн сэргээх арга хэмжээ рүү, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцно.

Ажлын хэсгийн дарга: _____ / Мөнх-Эрдэнэ /

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: _____ / Ө.Маналжав /

Гишүүд:

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн _____ / Б.Мөнхжаргал /

Аймгийн БОАЖГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч _____ / Ц.Батбуян /

Сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн _____ / Н.Солонго /

Сумын Засаг даргын орлогч _____ / Х.Галбадрах /


Сумын Байгаль хамгаалагч _____ / Б.Баярбаясгалан /

Сумын газрын даамал _____ / Т.Эрдэнэзаяа /

Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл /багийн Засаг дарга / _____ / Б.Мөнх-Оргил /

Хүлээн зөвшөөрсөн:

"Түшиг интернэйшнл" ХХК-ны _____





**ХЭНГИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН
ЗАСАГ ДАРГА**


23185 Бор-Өндөр, Бор-Өндөр сум
Утас: 70-56-74-88

2023. 11. 22 № 775
танай _____-ны № _____-т

ТҮШИГ-ИНТЕРНЕЙШНЛ ХХК-Д

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлага “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Бор-Өндөр сумын Засаг даргын А/81 тоот захирамжийн дагуу тус компани нь Хүйх 5 дугаар багийн цэвэрлэх байгууламжийн 2га талбай болон өөрсдийн эзэмшлийн талбайд нийт 300 ширхэг хайлаас мод тарьж ургуулсан нь үнэн болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Х.ГАЛБАДРАХ

Хэнтий аймаг Бор-Өндөр сум Дархан сумтай хийсэн гэрээ 3 жил хүчин төгөлдөр үйлчилнэ.

Гэрээний дагуу 10 сая төгрөг хандивласан.

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар: 2021/007

Чингис хот

Энэхүү гэрээг Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутаг дэвсгэрт **Хүдрийн биет 16-2** нэртэй **MV-018936** дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй **“Түшиг-Интернэшнл” ХХК** (цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх)-тай нутгийн захиргааны байгууллага дараах нөхцөлөөр харилцан тохиролцож, хамтран ажиллахаар байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, аймаг, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил, хүний хөгжлийг дэмжих, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжил, хүний хөгжлийг дэмжих, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр сайн дурын үндсэн дээр дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

Хоёр. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал хайх, ашиглах, олборлох болон бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах нөхцөлөөр дэмжих

2.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах, уг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх

2.1.3. Байгаль орчныг хамгаалах талаар Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хяналт шалгалт хийх, олборлолтын явцад байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэсэн тохиолдолд сөрөг нөлөөллийг арилгуулах арга хэмжээг авч ажиллах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох

2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд уг үүргээ биелүүлтэл, гарсан зөрчлийг арилгах хүртэл хуулийн хүрээнд холбогдох арга хэмжээг авах

2.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдсон хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх

2.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг холбогдох байгууллагатай хамтран иргэд, аж ахуйн нэгжүүдэд ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах

2.1.7. Энэхүү гэрээний 3.1.4-т заасан аймгийн Орон нутгийн төсвийн орлогын дансанд шилжүүлсэн мөнгөн дэмжлэгийн 40 хүртэлх хувийг тухайн тусгай зөвшөөрөлтэй талбай орших Бор-Өндөр, Дархан сумдын Орон нутгийн төсвийн орлогын дансанд тухай бүр шилжүүлнэ.

2.1.8. Орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрсөн мөнгөн дэмжлэгийг **“Орон нутагт шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх”** журмын дагуу зарцуулах ба хэрэгжилтэд тусгайлан хяналт тавьж, иргэд олон нийтэд мэдээлнэ.

2.1.9. Орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр үзүүлсэн дэмжлэг, туслалцаа, түүний зарцуулалт болон бусад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл хийж саналыг нь авах, тайланг аймгийн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөл”-д хүргүүлэх, нийтэд ил тод мэдээлэх ажлыг хариуцан ажиллана.

2.1.10. Энэхүү гэрээг хүчин төгөлдөр болмогц ажлын 3 өдөрт багтаан аймгийн нэгдсэн www.khentii.gov.mn цахим хуудас болон www.iltodgeree.mn эрдэс баялгийн гэрээний цахим мэдээллийн санд байршуулна.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг.

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэд, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлаар зохих журмын дагуу шат шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хандаж шийдвэрлүүлэх

3.1.2. Нутгийн захиргааны байгууллагаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах

3.1.3. Тусгай зөвшөөрөл бүхий талбайд Монгол улсын хууль, тогтоомж эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг хүндэтгэн биелүүлж, тавьсан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллах

3.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг болгож 2021 оноос эхлэн 2024 он дуустал жил бүр **20000000** /хорин сая/ төгрөгийг Хэнтий аймгийн Орон нутгийн төсвийн Бусад орлогын дансанд шилжүүлнэ.

Банкны нэр: Төрийн сан банк
Дансны нэр: Хэ. Бусад нэр заагдаагүй орлого
Дансны дугаар: 100180000955

3.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 3.1.4-т заасан сайн дурын үндсэн дээр үзүүлэх тухайн оныхоо санхүүгийн дэмжлэгийг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор бүрэн шилжүүлж дуусгасан байна.

3.1.6. Орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар мэдээлэл, тайлан авах

3.1.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээ, мэдээллийг аймгийн нэгдсэн цахим www.khentii.gov.mn хаягны “хариуцлагатай уул уурхай” хуудсанд ил тод нээлттэй байршуулах

3.1.8. Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл болон хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн талаар орон нутгийн иргэдэд танилцуулах ажлыг нутгийн захиргааны байгууллагатай хамтран жил бүрийн 4, 10 дугаар саруудад үр дүнтэй зохион байгуулж, иргэдийн саналыг авч үйл ажиллагаанд тусгаж, хэрэгжүүлэн ажиллана.

3.1.9. Гамшгийн үед тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх

3.1.10. Нутгийн захиргааны байгууллага, холбогдох төрийн байгууллагаас зохион байгуулж буй салбарын үйл ажиллагаатай холбогдох сургалт, зөвлөгөөн, олон нийтийн арга хэмжээнд компанийн оролцоог хангаж, төлөөллөө идэвхитэй хамруулах

3.2. Ажиллагсдын амьдрах, хөдөлмөрлөх орчин нөхцөл, нийгмийн хамгааллын талаар:

3.2.1. Ажилтан ажиллагсдын амьдрах, хөдөлмөрлөх орчин нөхцлийг Монгол улсын холбогдох стандартад нийцүүлнэ.

3.2.2. Ажилтан, ажиллагсдын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг Монгол улсын Засгийн газраас баталсан нийгмийн зөвшилцлийн гурван талт хэлэлцээрээр Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарт тогтоосон цалингийн жишгээс доошгүйгээр тогтооно.

3.2.3. Ажилтан, ажиллагсдын амьдрах байр, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчинг эрүүл, ахуйн стандартын дагуу тохижуулж, ажилтан, ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх иж бүрэн үзлэг, оношлогоонд тогтмол хамруулна.

3.2.4. Ажлын байран дахь осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, ХАБЭА-н хуваарьт сургалтыг улирал тутам тогтмол зохион байгуулж, үр дүнгийн талаарх тайлан мэдээллийг аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд хүргүүлнэ.

3.3. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

3.3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуул, ашиглалт, бусад үйл ажиллагааны явцад тусгай зөвшөөрөлтэй талбайд орших булаг шанд бүхий газрыг хөндөхгүй, ургамал, ан амьтан, байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй ба түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалж ажиллана.

3.3.2. Үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцлагатай, үр дүнтэй зохион байгуулж, сөрөг нөлөөлөл бий болж, байгаль орчны бохирдол үүссэн тохиолдолд нөхөн сэргээх ажлыг хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж, мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгнө.

3.3.3. Тухайн жилийн Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд байгаль

хэмжээг тусгахдаа нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллагын саналыг авах ба төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж, хуулийн хугацаанд дүгнүүлж ажиллана.

3.3.4. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгаж батлуулсан байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний нийт зардлын 50 хүртэлх хувийг холбогдох хуульд заасны дагуу барьцаа болгон тухайн сумын Байгаль орчны нөхөн сэргээлтийн дансанд үйл ажиллагаа эхлэхээс өмнө байршуулна.

3.3.5. Хоёр жил тутамд байгаль орчны аудит хийлгэнэ.

3.3.6. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны дүгнэлтийг жил бүр холбогдох мэргэжлийн байгууллагаар гаргуулж, ус ашигласны төлбөр, АМНАТ, газрын төлбөр, хог хаягдлын хураамж, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, ХХОАТ зэргийг хуулийн хугацаанд төлөх, тайлагнах үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллана.

3.3.7. Ашигт малтмал олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ус хамгийн багаар хэрэглэгддэг тэргүүний дэвшилтэт, байгальд ээлтэй технологи нэвтрүүлж ажиллах ба үйлдвэрлэлд ашигласан саарал усыг дахин ашиглана.

3.4. Зам тээвэр дэд бүтцийн чиглэлээр:

3.4.1. Бүтээгдэхүүн тээвэрлэх автозамын чиглэл маршрутыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу батлуулна.

3.4.2. Маршрутын дагуу бүтээгдэхүүн тээвэрлэх хүнд даацын авто машины тоо, даацын хэмжээ, бусад мэдээллийг холбогдох байгууллагад бүртгүүлж автозам, гүүрийг ашиглах зөвшөөрөл авна.

3.4.3. Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2011 стандартын дагуу автотээврийн хэрэгслийн бүх жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг 44 тонноос хэтрүүлэхгүйгээр бүтээгдэхүүн тээвэрлэнэ.

3.4.4. Бүтээгдэхүүн тээвэрлэхдээ хөрсний доройтол, салаа зам, тоосжилт үүсгэхгүй байна. Мөн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн автозамын засвар арчлалтыг хийхэд шаардлагатай хөрөнгийг тухайн жилийн үйл ажиллагааны төсөвтөө тусган, шаардлагатай техник хэрэгслийг гаргаж, жилд хоёроос доошгүй удаа засвар арчлалтыг хийж ажиллана.

3.4.5. Автозамын засвар арчлалтын ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг авч хамтран төлөвлөнө.

3.5. Ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлт, хүний хөгжлийг дэмжих чиглэлээр:

3.5.1. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байраар хангаж ажиллана.

3.5.2. “Орон нутагт шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх” журмын дагуу нутгийн захиргааны байгууллагатай хамтарч ажиллана.

3.5.3. Салбарын мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг дадлага хийх нөхцөл боломжоор хангана.

3.5.4. Уурхайн нийт ажилтан, ажиллагсдын 80-аас доошгүй хувийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан холбогдох журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулж авна.

3.5.5. Уурхайн ажилтан, ажиллагсдыг сонгон шалгаруулж авахдаа Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагад бүртгэлтэй Цэнхэрмандал сумын болон Хэнтий аймгийн иргэдэд давуу эрх олгож тэргүүн ээлжинд сонгон авна.

3.6. “Нийгмийн хариуцлага”-ыг нэмэгдүүлэх бусад чиглэлээр:

3.6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хүнс, бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авах жагсаалтыг гаргаж, тухайн оны эхний улиралд багтаан Аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

3.6.2. Худалдан авах ажлыг ил тод, нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг шударга хийж, бараа бүтээгдэхүүн худалдан авалт болон бусад туслан гүйцэтгэх ажил, үйлчилгээний 50-аас доошгүй хувийг Хэнтий аймгийн татварын хэлтэст бүртгэлтэй, аймгийн болон тухайн сумын жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэд, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгжүүдэд давуу эрх олгон гүйцэтгүүлнэ.

3.6.3. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл, холбогдох тайлан мэдээг хагас болон бүтэн жилээр гаргаж аймаг, сумын Засаг даргад жил бүрийн 6 болон 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ.

Дөрөв. Хамтын ажиллагааны хороо

- 4.1. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "Хороо" гэх)-г төрийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна. Иргэдийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн хурлаас нэр дэвшүүлнэ.
- 4.2. Хорооны ажиллах журмыг аймгийн Засаг дарга батлах бөгөөд бүрэлдэхүүнийг сумын Засаг дарга нэр дэвшүүлж, аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.
- 4.3. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна.

Тав. Тайлагнах, дүгнэх

- 5.1. Хамтын ажиллагааны хороо нь гэрээний биелэлтэд жил бүр хяналт тавьж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.
- 5.2. Талууд Хамтын ажиллагааны хорооны тайлантай танилцан, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа дэвшүүлэн, тайланг дараа оны 02 дугаар сард багтаан аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлнэ.
- 5.3. Талууд гэрээний биелэлтийг дүгнэж, хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар нутгийн захиргааны байгууллага, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

Зургаа. Хариуцлага, маргаан шийдвэрлэх

- 6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээний хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу зохих хариуцлага хүлээх бөгөөд энэ нь хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.
- 6.2. Талуудын хооронд гэрээтэй холбоотой үл ойлголцол, маргаан үүссэн тохиолдолд хэвийн ажиллагааг хангах нөхцөлөөр харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба зөвшилцөлд эс хүрвэл холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Долоо. Гэрээний хугацаа, гэрээг цуцлах

- 7.1. Энэхүү гэрээг 4 жилийн хугацаатай байгуулав.

7.2. Гэрээний аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзсан, удаа дараа ноцтой зөрчсөн тохиолдолд нөгөө талын санаачлагаар гэрээг цуцалж болно. Гэрээг зөвхөн хууль болон энэ гэрээнд заасан үндэслэлээр цуцална.

7.3. Гэрээний хугацаа дууссанаар гэрээ дуусгавар болно.

7.4. Талуудын аль нэг нь байгалийн болон гэнэтийн давагдашгүй нөхцөл байдлын улмаас гэрээнд заасан үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээс харилцан чөлөөлөгдөнө.

Найм. Бусад

8.1. Хамтын ажиллагааны энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусад туслан гүйцэтгэгч нарт нэгэн адил үйлчилнэ.

8.2. Талууд гэрээний 5.1-т заасан тайланг харгалзан гэрээг дүгнэж, шаардлагатай тохиолдолд аль нэг талын санаачлагаар харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг байна.

8.3. Гэрээг Монгол хэлээр 3 хувь үйлдэж, талууд тус бүр 1 хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Ц.ИДЭРБАТ

БОР-ӨНДӨГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА П.ЧИНБАТ

ДАРХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Ж.ЭНХТӨР

АЖ АХУЙН НЭГЖИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Түшиг-Интернэшнл" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
С.ЧУЛУУНЦЭЦЭГ

/гарын үсэг, тамга/

Утас: 99113241

Хаяг:



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар **0011728**

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: *"Турши интерконтин" АЖ*

Хаяг: *Бүр-Ондор сум 3-р баг*

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: *Туршилт*

аншиглалтын байр

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, / гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж /анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/

Олгосон: *2023* он *06* сар *27* өдөр

Хүчинтэй хугацаа: *2025* он *06* сар *27* өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

Хэнтий аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга *Хураандаа* цолтой *А. Сүхбат* *А. Чинбат*

Дүгнэлт гаргасан: *5 ± 2319281175*

Хэнтий аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч: *С. Шааг* цолтой *Р. Цэвэг*

/гэмдэг дарна/





Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0004347

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: *"Аушиа интернэшнл" ХХК*

Хаяг: *Бор-Ондор су.м 3 дугаар Үед*

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: *Тээвэр Регистр*

Ажлын байр, амьжиргаа, хөдөлгөөн 40 тн

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2/

Олгосон: *2023* он, *06* сар *27* өдөр

Хучинтэй хугацаа: *2024* он, *06* сар *27* өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

дарга: *Хүраандаа* аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ цолтой *С.Солонго А.Чинбат*

Дүгнэлт гаргасан:

Гал түймрийн улсын хяналтын байцаагч: *А.Хюг* аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ цолтой *Р.Амар*

/гэмдэг дарга/



Хог хаягдлын 2,676,000₮ төлбөрийг энэ 7 хоногтоо хийнэ.


Бор-Өндөр хот тохижилт ТБАГУТУГ-ын
ДаргаЭ.Эрдэнэбат


Батлав
“Түшиг Интэрнешнл” ХХК –н
Захирал.....С.Чулуунцэцэг

**Бор-Өндөр хот тохижилт Орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар
Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ**

№

2023 он 09 сар 07 өдөр

Бор-Өндөр сум

Нийтлэг үндэслэл

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар бүлэг 4-ийн 30.2.1, 30.2.2 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хууль 21 дүгээр зүйл 3-ын 4дахь заалт, Хог хаягдалын тухай хуулийн 9-р зүйлийн 9.1-9.5, 12.4 дахь заалтыг тус тус ҮНДЭСЛЭХ НЬ:

Нэг талаас “Бор-Өндөр хот тохижилт” ТБАГУТУГ-ын нягтлан бодогч **Б.Энхтуяа** “А” тал гэх, нөгөө талаас “Түшиг интэрнешнл” ХХК-г төлөөлж **У.Отгонтуяа** ”Б” тал гэх бид харилцан тохиролцож доорх гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1. Аж ахуй нэгж байгууллага, иргэний хог хаягдлыг батлагдсан хуваарийн дагуу ачиж, тээвэрлэх, тус байгууллага өөрөө ачиж тээвэрлэх, устгах тухайн иргэн, ААНБайгууллага цаг хугацаандаа төлбөр тооцоогоо барагдуулахыг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний үндсэн нөхцөл

- 2.1. Ажил явагдах газар: Бор-Өндөр сум, ААН, Албан байгууллага, айл өрх
- 2.2. Үйл ажиллагааны чиглэл: ААНБайгууллага айл өрх өдөр тутмын орчин тойрны цэвэрлэгээ. Хог ачилт тээвэрлэлт, хог устгал хийх.
- 2.3 Бор-Өндөр хот тохижилт ТБАГУТУГ нь дуудлага ирсэн тухай өдөр хог хаягдыг ачиж тээвэрлэх.
- 2.4 Их хэмжээний хог хаягдал /барилгын хог г.м / гарсан бол дуудлага өгч төлбөртэй ачуулна .
- 2.5 Тухайн ААН байгууллага нь өрөө хогоо ачиж тээвэрлэж хогийн цэгт хүргэх нөхцөлтэй.

Гурав: “А” талын эрх үүрэг

- 3.1. Иргэн ААНБ-ын гадаад орчны тохижилт, цэвэрлэгээнд үүрэг өгөх шалгах, шаардлага тавих эрхтэй.
- 3.2. Мөн нийтийн цэвэрлэгээ, засварын их хэмжээний хог хаягдалыг аймгийн ИТХ Тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 08 дугаар тогтоолын 1 дүгээр

хавсралт Хог хаягдлын үйлчилгээний хураамжын дагуу , тогтоосон үнэ тарифыг төлсөний дараа үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй

Дөрөв: “Б” талын эрх үүрэг

- 4.1. Орчин тойрноо цэвэр цэмцгэр байлгахын тулд ил задгай хог хаягдалаа хаяхгүй байж, гадна талбайд цэвэрлэгээ хийж,нийтийн цэвэрлэгээнд оролцож цэвэр орчин бүрдүүлж ажиллах үүрэгтэй.
- 4.2. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуй нэгж байгууллагын хог хаягдлыг үйлчилгээний хураамжийн дагуу сар бүр **223 000** /Хоёр зуун хорин гурван мянган төгрөг/-ийг тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулсан хугацаагаар он дуусахаас өмнө хог хаягдалын суурь болон үйлчилгээний хураамжыг төлж барагдуулах үүрэгтэй.
- 4.3 Үйл ажиллагааны хүрээнд ойр орчимын байгаль орчиныг цэвэрлэх хор хөнөөлтэй хортой хог хаягдал ил задгай хаяхгүй байх.
- 4.4. Зориулалтын цэгээс бусад цэгт хог хаягдал хаяхгүй байх. хогийн цэгд гүйцэд хогоо оруулж буулгах үүрэгтэй.

Тав. Хариуцлага

5.1 Хог хаягдал хаясан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон тохиолдолд Хог хаягдлын тухай хуулийн 23–р зүйлийн 23.1.1, 23.1.2 -т заасны дагуу зориулалтын бус газар хог хаягдал хаясан үндэслэлээр:

-Иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр -ААНБ нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх:

Зургаа. Бусад зүйл

- 6.1. Хоёр тал гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.
- 6.2. Гэрээг 2% үйлдэж нэг хувийг “Түшиг интэрнешнл” ТБАГУТҮГ, нэг хувийг “Баян арвин ундрага” ХХК -д байна.
- 6.3. Гэрээний нөхцөл зөрчигдсөн тохиолдолд хоёр тал харилцан хэлэлцэж шийдвэрлэнэ.

Долоо. Гэрээ байгуулалт

- 7.1. Гэрээ нь хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулсанаас хойш..... жилийн хугацаатай /хугацаагүй хүчин төгөлдөр байна.
- 7.2. Гэрээний нөхцөл өөрчлөгдөөгүй, мөн хоёр талын аль нэг талаас санал гарган цуцлаагүй тохиолдолд хүчин төгөлдөрт тооцно.

Гэрээ байгуулсан

“Бор-Өндөр Хот Тохижилт” ТБАГУТҮГ-ыг

Төлөөлж ня-бо:

.....*Б.Энхтуяа*.....
Утас: 99036601

“Түшиг интэрнешнл” ХХК -г

Төлөөлж менежер:

.....*У.Отгонтуяа*..... У.Отгонтуяа

Утас:99534213



Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/719/189 дүгээр тушаалын хавсралт




ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Умарз говийн гүвээт - халхын гууцаг талын
сав газрын захиргаа-ын гаргасан
/ Дүгнэлт гаргасан байгууллага /
2022 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах 199 тоот
дүгнэлтийг үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэл Баянзүрх
сум/дүүргийн 4 дүгээр хороо байршилтай
/ хаяг /
Хайлээр Жоншны хүдэр олборлох
/ үйл ажиллагааны чиглэл /
чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа С.Гүлчунцагаг -д
/ хүн, хуулийн этгээдийн нэр /
Хэнтий аймаг/нийслэл, Бор-Өндөр сум/дүүргийн
Өлгий 6 дугаар багт байршилтай хаягдал
ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны
шугамд жилд 1160 мян.м³ хаягдал усыг “Хүрээлэн байгаа
орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015”,
“Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд
нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартаар
тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг
/ аль нь болохыг доогуур нь зурах /
нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон
дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно.
Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны
шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

Бор-Өндөр сумын
Засаг дарга
/ Зөвшөөрөл олгосон байгууллага /

Тамга

2022 оны 11-р сарын 11-ны өдөр



Г.Сүхбаатар
/ Г.Сүхбаатарийн тайлал /



**ХЭНГИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН
6 ДУГААР БАГ**

223185 Бор-Өндөр сум, Өлгий 6 баг
Утас: 70567143, 98080102


2023.09.08 № 02

танай _____-ны № _____-т

ТҮШИГ ИНТЕРНЭШНЛ ХХК-Д

Бор-Өндөр сумын Өлгий 6 дугаар багийн "Зүүн далантүрүү"-д үйл ажиллагаа явуулдаг уурхайн гүний усыг шавхан зайлуулсан усаа бэлчээрт урсгаад ойр орчимын малчин өрхүүдийн малыг ундаалдаг болно.

ЗАСАГ ДАРГА  Н. ӨТГОНБИЛЭГ





БАТЛАМЖ

“.....*Түүсийг илтгэнэмд*.....”-д

Уурхай, уулын үйлдвэрт ажиллагсадын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний мэдлэг олгох сургалтад хамрагдсан тул “Батламж” олгов.

Эрсдэлийг арилгаж, эерэг хандлагыг төлөвшүүлцгээе.

УУЛ УУРХАЙН АВРАХ 09 ДҮГЭЭР АНГИ

2023 он

Сумын баяр наадам-аар 4 сая төгрөг хандивласан



**БОР-ӨНДӨР СУМЫН
БАЯР НААДМЫН КОМИСС**

23185 Бор-Өндөр сум, Бор-Өндөр 1 баг
Утас: 88887811, 7056-7488

2023.07.03 № 02.
танай _____-ны № _____-т

“ТҮШИГ ИНТЕРНЭШНЛ” ХХК-Д


Жил бүрийн сумын баяр наадмын бай шагналд дэмжлэг туслалцаа үзүүлдэг танд болон танай хамт олонд талархал илэрхийлье.

Энэ жилийн Бор-Өндөр сумын баяр наадам 2023 оны 07 сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулагдана.

Иймд нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана уу.

Хүндэтгэсэн:

ДАРГА



Х.ГАЛБАДРАХ



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ТЭСРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ
АШИГЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС 23/134

Тэсэлгээний ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл: ТЭСРЭЛТИЙН ХҮЧ ХХК ХХК,
2020.08.17, 545

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: ТУШИГ ИНТЕРНЭШНЛ ХХК,
MV-018936

Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ: 2023.05.27, 23/07

Төслийн баталгаажсан баримт бичиг: Хүдрийн биет 16-2 хайлуур жоншны ордын
2023 оны батлагдсан уулын ажлын төлөвлөгөө

Тэсэлгээний ажлын байршил, зориулалт: Хэнтий аймгийн Дархан сум, Хүдрийн биет
16-2 далд уурхайд

Тэсрэх материалын хадгалалт: Хэнтий аймгийн Бор-өндөр сумын нутагт байрлах
Түшиг интернэшнл ХХК-ийн тэсрэх материалын агуулахад Хүчит везон ХХК-ийн харуул
хамгаалалтад хадгална. Агуулахын няраваар Д Дуламрагчаа ажиллана.

№	Тэсрэх материалын нэр	Хэмжих нэгж	Нийт хэмжээ	
			Тоо	Үсгээр
1	Эмульс	кг	126000	Нэг зуун хорин зургаан мянга
2	Цахилгаан бус тэслүүр / цооног/	ш	92761	Ерэн хоёр мянга долоон зуун жаран нэг
3	Цочир дамжуулах шижим	м	92464	Ерэн хоёр мянга дөрвөн зуун жаран дөрөв
4	Цахилгаан тэслүүр	ш	98464	Ерэн найман мянга дөрвөн зуун жаран дөрөв

Тэсэлгээний ажлыг инженер Д.Лхагва удирдан, тэсэлгээчин П.Батболд нар
"Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийн заалтуудын дагуу аюулгүй
ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, тэсэлгээний ажлыг явуулна.

Онцгой нөхцөл: Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалтад тавих дотоодын
хяналтыг сайжруулах, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл авах бүр орон нутгийн цагдаагийн
байгууллагад мэдэгдэж байна.

Хүчинтэй хугацаа: 2023.12.31

УУХҮЯ-ны Салбарын хяналтын газрын дарга бөгөөд
Салбарын улсын ерөнхий байцаагч **Б.Мөнхдөл**

Хяналтын хуудас олгосон:
Улсын ахлах байцаагч **Д.Пүрэвбат**

Хяналтын хуудас авсан:
Тэсрэлтийн хүч ХХК-н ажилтан **В.Отгонсүрэн**





“БАЯН ХАНГАЙ КОНСАЛТИНГ” ХХК-д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 7000 3959,
Факс: (976-11) 32 26 83, И-mail: info@gazar.gov.mn

2020.11.20 № 1/2269
танай 2020.10.23-ны № А/20/56 -Т

Дүгнэлт баталгаажуулсан тухай

Монгол Улсын “Газрын тухай хууль”-ийн 58 дугаар зүйл, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-ын 3.6-д заасны дагуу “Түшиг Интернэшнл” ХХК-ийн захиалгаар танай компанийн хийж гүйцэтгэсэн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах MV-018936 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, хайлуур жоншны ордын зориулалттай газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын дүгнэлтийг баталгаажуулан 2 хувь хүргүүлэв.

Хавсралт 3 хуудастай, 2 хувь.

ДАРГА



Ц. ГАНХҮҮ

0800005453

“МОН ГАЗАР КОНСАЛТИНГ” ХХК

Байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллага

“ТҮШИГ ИНТЕРНЭШНЛ” ХХК-ИЙН ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮДРИЙН БИЕТ 16-2” ЖОНШНЫ ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН



Улаанбаатар хот

2023 он

“МОН ГАЗАР КОНСАЛТИНГ” ХХК

Байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллага

“ТҮШИГ ИНТЕРНЭШНЛ” ХХК-ИЙН ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХҮДРИЙН БИЕТ 16-2” ЖОНШНЫ ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН



Тайлан боловруулсан:

“Мон газар консалтинг” ХХК-ийн

захирал бөгөөд ахлах аудитор:

Аудитор:

Аудитор:

Туслах аудитор:



Доктор Ю.Дэлгэрмаа

Доктор Б.Даваажаргал

Доктор Ч.Сономдагва

Магистрант Б.Баярцэцэг

Улаанбаатар хот
2023 он

ГАРЧИГ

1.	АУДИТЫН ЗОРИЛГО	4
2.	АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ	4
2.1.	БОА-ын оронзайн хамрах хүрээ	4
2.2.	БОА-ын техник, технологийн хамрах хүрээ	7
2.3.	Цаг хугацааны хамрах хүрээ.....	8
2.4.	Хууль эрхзүйн хамрах хүрээ	8
3.	АУДИТЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ.....	11
3.1.	Аж ахуй нэгжийн нэр	11
3.2.	Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар болон регистрийн дугаар	11
3.3.	Аж ахуй нэгжийн хаяг, байршил	11
5.	АУДИТ ХИЙХ ГАЗАР БОЛОН ЭХЛЭХ, ҮРГЭЛЖЛЭХ, ДУУСАХ ХУГАЦАА.....	12
5.1.	Аудит хийх газар	12
5.2.	Аудитын шалгуур.....	12
6.	АГААР ОРЧНЫ АУДИТ	13
6.1.	Аудитын зорилго	13
6.2.	Аудитын хамрах хүрээ	13
6.3.	Аудитын шалгуур.....	14
6.4.	Баталгаажсан нотолгоо.....	14
6.5.	Аудитын үнэлэмж:	14
6.6.	Үл нийцлийн эрсдэл:	14
6.7.	Зөвлөмж:.....	15
6.8.	Аудитын дүгнэлт:.....	15
7.	ГАЗАР, ТҮҮНИЙ ХЭВЛИЙ, ХӨРС ХАМГААЛЛЫН АУДИТ	18
7.1.	Аудитын зорилго:	18
7.2.	Аудитын хамрах хүрээ:	18
7.3.	Аудитын шалгуур:.....	19
7.4.	Баталгаажсан нотолгоо:.....	19
7.5.	Аудитын үнэлэмж	19
7.6.	Зөвлөмж.....	19
7.7.	Аудитын дүгнэлт:.....	20
8.	УСАН ОРЧНЫ АУДИТ	23
8.1.	Аудитын зорилго:	23
8.2.	Аудитын хамрах хүрээ:	23
8.3.	Аудитын шалгуур:.....	24
8.4.	Баталгаажсан нотолгоо:.....	24
8.5.	Аудитын үнэлэмж:	25

8.6. Үл нийцлийн эрсдэл:	25
8.7. Зөвлөмж:.....	25
8.8. Аудитын дүгнэлт:.....	25
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АУДИТ	29
9.1. Аудитын зорилго:	29
9.2. Аудитын хамрах хүрээ:	29
9.3. Аудитын шалгуур:.....	30
9.4. Баталгаажсан нотолгоо:.....	30
9.5. Аудитын үнэлэмж:	30
9.6. Үл нийцлийн эрсдэл:	30
9.7. Зөвлөмж:.....	31
9.8. Аудитын дүгнэлт:.....	32
10. НЭГДСЭН ДҮГНЭЛТ	40

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хууль эрхзүйн баримт бичиг	8
Хүснэгт 2. Аудитын багийн гишүүдийн мэдээлэл	11
Хүснэгт 3. Агаар орчны аудитын нэгдсэн хүснэгт	16
Хүснэгт 4. Газар, хөрс хамгааллын аудит	21
Хүснэгт 5. Усны менежментийн аудитын хүснэгт	27
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн аудит	33

ТОВЧИЛСОН ҮГС

АТХ	Агаарын тухай хууль
АМТХ	Амьтны тухай хууль
БОА	Байгаль орчны аудит
БОАЗХТ	Байгаль орчны аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОМТБТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан
БОНЕУ	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ
УА	Уур амьсгал
СҮЗ	Стандартчилалын үндэсний зөвлөл
УСШУТЗ	Улсын стандарчиллын шинжлэх ухаан техникийн зөвлөл

1. АУДИТЫН ЗОРИЛГО

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт байрлах “Түшиг Интернэшнл” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төсөлд байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн аудитыг хийснээр төслийн одоогийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, засч залруулах арга хэмжээ авах арга зам, цаашид байнгийн сайжруулах боломж бий болгож улмаар компанид учирч болзошгүй эрсдэл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаж, урьдчилан сэргийлэх болон орон нутгийн иргэд, ажилчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрэн бий болгоход нь тусалж дүгнэлт зөвлөмж өгөхөд энэхүү аудитын ажлын үндсэн зорилго оршино.

Байгаль орчны аудитын ажлын үндсэн зорилгодоо хүрэхийн тулд бид дараах дэд зорилтуудыг тавьж ажиллалаа. Үүнд:

- ✓ Байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын шаардлагыг олж тогтоох
- ✓ Тэдгээр хууль, дүрэм, журам стандартуудын шаардлагыг үйлчлүүлэгч байгууллага өөрийн үйл ажиллагаандаа хэрхэн нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаад дүн шинжилгээ хийх
- ✓ Аудитаар илэрсэн зүйлст дүгнэлт, зөвлөмж өгөх
- ✓ Цаашид сайжруулах арга хэмжээг төлөвлөх

2. АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. БОА-ын оронзайн хамрах хүрээ

Тус аж ахуй нэгжийн эзэмшиж буй МУ-018936 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь нийт 28.07 га бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 310 км, Бор-Өндөр өртөөнөөс 3.0 км-т тус тус байрлана.

2013 оны 6-р сарын байдлаар хүдрийн биет 16-2 нэртэй ХҮ-011644 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах талбайд бодитой болон боломжтой зэргийн нөөцийг 38.27%-ийн дундаж агуулгатай 270195.59 тн хүдэрт 103408.04 тн хайлуур жоншны нөөц хүлээн авсан. Үүнээс бодитой зэргийн нөөцийг 42.55%-ийн дундаж агуулгатай 232513.14 тн хүдэрт 98946.71 тн хайлуур жонш, боломжтой зэргийн нөөцийг 11.84%-ийн дундаж агуулгатай 37682.45 тн хүдэрт 4461.33 тн хайлуур жоншны нөөцийг тус тус хүлээн авсан байна.

Ашигт малтмалын МУ-018936 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Хүдрийн биет 16-2” нэртэй 28.07 га талбайд өмнөх хайгуулын үед тогтоогдсон (XV шугамаас XVII шугам хүртэлх) хүдрийн биет хамаарагддаг. Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд багтаж буй хүдрийн биет нь газрын гадарга дээр 170 метр урттай 4.55 метрийн дундаж зузаантай 1 хүдрийн биет илэрдэг бөгөөд 1984 оны өрөмдлөг болон бидний малтсан хэвтээ малталтын үр дүнгээс харахад хүдрийн биет нь 1305 метрийн түвшингээс (газрын гадаргаас 26 м-ын гүнд) доош 2 зэрэгцээ хүдрийн биет болон тогтсон байдаг.

2010-2012 онд хайгуулын нөөцийг тодотгох явцад хийсэн шурф малталтыг уурхайн үндсэн босоо ам ствол №1 ба № 2 болгон төлөвлөж 70м болон 74 м гүн нэвтэрсэн. Эдгээрээс босоо амнуудад 30м 50м 70м түвшинт хэвтээ нэвтрэлт хийгдсэн. Хүдрийн судлын зүүн баруун хойш чиглэсэн жигүүрийн дагуу хэвтээ малталтыг 100 м нэвтэрч байна.

“Хүдрийн биет 16-2” хайлуур жоншны орд нь Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сумдын нутагт сумдын нутагт буюу Бор-Өндөр тосгоноос баруун хойш 5 км-т оршдог. Тус бүс нутаг нь эрчим хүчний хувьд сайн хөгжсөн бүсэд оршдог. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумаас Дархан сум хүртэл 35кВт-ын өндөр хүчдэлийн агаарын шугамаар холбогдсон. “Хүдрийн биет 16-2” жоншны орд нь Бор-Өндөр сумаас Дархан сумдыг холбосон агаарын цахилгаан дамжуулах шугамын 16-р шонгоос агаарын шугам 0.5 км-т татаж ТМН1000/6 трансформаторын дэд станц байгуулан энэ станцаас 500м, 6кВ-ын агаарын шугамыг 2014 онд ашиглалтад өгсөн байна.

Уурхай нь ашигт малтмалыг олборлох, зөөж тээвэрлэх, баяжуулах, хэрэглэгчид худалдан борлуулах үйл ажиллагааг тасралтгүй хангахад зориулагдсан төрөл бүрийн машин, механизм, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон газрын дээрх, доорх барилга байгууламжаас бүрдэнэ.

- Далд уурхайн их амны дээр байрлуулсан цамхаг (копер). Өргөх байгууламжийн дaмap, cкип, канат болон ашигт малтмал өргөж гаргах бусад байгууламж, бэхлэх зориулалттай уурхайн их амны дээр байрлуулсан цамхаг бөгөөд цамхагийн өндөр нь 12м байна
- Уурхайн газар дээрх барилга. Энэ барилга нь уурхайд орох ачааг хүлээн авах, хувиарлах, түүнийг ачиж буулгах байгууламж, бусад тоног төхөөрөмж байрлуулах үүрэгтэй.
- Ангилян ялгах цех. Ашигт малтмал баяжуулах, сортлон ангилах, томчлон ялгах /чанарыг сайжруулах/ зориулалттай машин механизм, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.
- Өргөлтийн машины барилга. Өргөлтийн машины барилга дотор өргөлтийн канат, клетийн тусламжтайгаар хүмүүс болон ачаа бусад материалыг уурхайд оруулах, гаргахад зориулагдсан өргөлтийн машиныг байрлуулна
- Уурхайг агааржуулах вентиляторын барилга. Далд уурхайн малталтуудыг агааржуулахад зориулагдсан төхөөрөмжүүд байрлуулна.
- Компрессорын барилга. Газрын гүнд ажиллаж байгаа машин механизмуудыг өндөр даралттай хийгээр хангах, хийн төхөөрөмжүүд байрлуулна.
- Цахилгааны дэд станц. Уурхайн цахилгаан хангамжийн байгууламж нь чухал объект бөгөөд цахилгаан эрчим хүчийг хуваарилах, 6000В хүчдэлийг 220-380В хүртэл бууруулна
- Засварын цех. Уурхайн машин механизм, цахилгаан, тоног төхөөрөмжийн урсгал, бага дунд засваруудыг хийнэ
- Захиргаа аж ахуйн байр. Далд уурхайн газрын дээрх, доорх ажиллагсдад үйлчлэх үйлдвэрлэлийн албадуудыг нэгтгэсэн туслах чанарын барилга юм. Захиргаа аж ахуйн байранд ажиллагсдын хувцасны өлгүүр, халуун усны газар, гэрлийн тасаг, аваарын эмнэлэг болон захиргаа, аж ахуйн ажилтнуудын албан тасалгаанууд байрлана
- Шатах тослох материалын агуулах. Шатах тослох материалыг 10м³ -ийн багтаамжтай ган саванд хадгалах ба тосолгооны материалыг зориулалтын савтай нь хадгална. Шатах тослох материалыг техник аюулгүйн дүрмийн дагуу байрлуулан, гал түймрийн эсрэг арга хэмжээ болон ариун цэврийн шаардлагын дагуу тоноглон хамгаалалт хийсэн байна.
- Тэсрэх материалын агуулах. Тэсрэх материалын агуулахыг 10 тн-ын багтаамжтай байхаар бодож, тосгоноос 500м-ээс хол зайд байрлуулахаар цохилтын долгионы үйлчлэх зайн нормоор авав. Агуулахыг гүний хэлбэрээр байрлуулж, шороон далангаар хамгаалалт хийнэ.

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

- Технологийн хэрэгцээнд зориулсан усны 10 м³, ахуйн хэрэгцээний усны хэрэгцээнд 6м³-ийн ган савууд зэрэг барилга байгууламжууд байна.

Үйлдвэрийн барилга байгууламж буюу 4.271 га талбайд баригдсан барилгууд:

- 8 м өндөр уурхайн цамхаг – төмөр 2ш
- Өргөх машины барилга – Модон барилга
- Компрессорын барилга – Сендвичин барилга
- Уурхайн контор –Сендвичин барилга
- Ахуй үйлчилгээний барилга – тоосго
- Шатах тослох материалын агуулах – 20 м³-ын ёмкость



Зураг 1. Далд уурхайн амнууд



Зураг 2. Засварын газар, сэлбэр хэрэгсэлийн агуулах



Зураг 3. Уурхайн тосгон болон захиргааны байр



Зураг 4. Цахилгааны дэд станц

2.2. БОА-ын техник, технологийн хамрах хүрээ

Ордыг төв хэсэгт нь нээх тул ашиглах дараалал нь төвөөс 2 жигүүр рүү гэсэн байдалтай байна. Блокийг олборлож байх явцад дараа дараагийн бэлтгэл ажлууд хийгдсэн байх ёстой. Блокийг олборлож байхад дараагийн блокуудад хийгдэх ажил нь блокийг бэлтгэх, блокийг нээх ажлууд зэрэг явагдаж байна. Өөрөөр хэлбэл блокийг олборлож дуусахад тасралтгүй буюу цикл ажиллагааг алдагдуулахгүйн үүднээс дараагийн ажил явагдах блок бэлтгэгдсэн байна.

2.3. Цаг хугацааны хамрах хүрээ

Монгол улсын Байгаль хамгаалах тухай хуулийн 2012 оны нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хууль тогтоомжийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийнэ. “Түшиг Интернэшнл” ХХК-ийн 2021, 2022 оны байгаль орчны гүйцэтгэлд байгаль орчны аудит хийж гүйцэтгэсэн.

2.4. Хууль эрхзүйн хамрах хүрээ

Байгаль орчны салбарт 2022 оны байдлаар олон улсын гэрээ конвенц 22, хууль 36, бодлогын баримт бичиг 20, захиргааны хэм хэмжээний акт болон Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, яам, агентлаг, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас батласан эрхзүйн актыг мөрдөж байна. Эдгээрээс тус төслийн үйл ажиллагаанд хамаарах дараах хүснэгтэд үзүүлсэн хууль эрхзүйн хэм хэмжээний хүрээнд энэхүү БОА-г хийж гүйцэтгэсэн болно.

Хүснэгт 1. Хууль эрхзүйн баримт бичиг

Хууль эрх зүйн баримт бичиг	Батлагдсан огноо	Шийдвэрийн дугаар	Хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон огноо
Төрийн бодлого, үндэсний хөтөлбөр			
Алсын хараа 2050 баримт бичиг	2020.05.13	МУИХ-ын 52 тоот	
Шинэ сэргэлтийн бодлого	2021.12.30	МУИХ-ын 106 тоот	
Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого	2016.01.16	МУИХ-ын 18 тоот	
Монгол улсын хууль			
Агаарын тухай хууль	2012.05.17		2018.01.12
Ашигт малтмалын тухай	2006.07.08		2019.11.22
Агаарын төлбөрын тухай хууль	2010.06.24		2018.01.13
Эрүүл ахуйн тухай хууль	2016.02.04		2018.11.15
Амьтны тухай хууль	2012.05.17		2017.02.02
Газрын тухай хууль	2002.06.07		2019.05.02
Газрын хэвлийн тухай			
Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	2012.05.17		2015.12.04
Хог хаягдлын тухай хууль	2012.05.17		хүчингүй болсон
Хог хаягдлын тухай хууль	2017.05.12		
Усны тухай хууль	2012.05.17		2019.05.02
Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	2012.05.17		2019.05.02
Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай	2009.07.16		2015.12.04
Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2009.07.16		2015.02.18
Монгол улсын дүрэм, журам			

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах заавар	2014.05.19	БОНХ-ын сайдын А-181	
Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам	2018.12.26	МУЗГ-ын 391-р тогтоол	
Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам	2013.05.16	БОНХ-ын сайдын А156	
Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам	2015.06.05	БОНХАЖ/БХБ-ын сайдын А230/127	
Ус бохирдуулсаны төлбөрийн хэмжээ		МУЗГ-ын 316-р тогтоол	
Аюултай хог хаягдлын жагсаалт	2015.06.29	МУЗГ-ын 264-р тогтоол	
Хог хаягдлын норматив тогтоох аргачлал	2015.07.07	МУЗГ-ын 288-р тогтоол	
Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулал олгох журам	2015.06.29	МУЗГ-ын 264-р тогтоол	
Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүтгэх, тайлагнах, Аюултай хог хаягдлын ангилалын жагсаалт	2018.05.02	МУЗГ-ын 116-р тогтоол	
Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам	2015.03.30	МУЗГ-ын 120-р тогтоол	
Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар	2018.11.19	БОАЖ-ын сайдын А/445	
Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага	2018.11.17	БОАЖ-ын сайдын А/443	
Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам	2018.11.12	БОАЖ-ын сайдын А/428	
Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн ангилал	2017.12.12	БОАЖ-ын сайдын А/349	
Стандарт			
Агаарын чанар, ерөнхий шаардлага (MNS 4585:2016)	2016.06.23	СҮЗ-ийн 37-р тогтоол	
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Хөдөлмөрийн эрүүл ахуй,	2015.09.24	СҮЗ-ийн 32-р тогтоол	

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

Ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага-MNS 4990:2015			
Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд-MNS 3298:1991	1991.04.25	УСШУТЗ-ийн 16-р тогтоол	
Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ-MNS 5850:2008	2008.05.30	СҮЗ-ийн 17-р тогтоол	
Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт-MNS 5916:2008	2008.11.27	СҮЗ-ийн 61-р тогтоол	
Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага-MNS 4943 : 2015	2015.12.24	СҮЗ-ийн 50-р тогтоол	
Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010	2010.09.30	СҮЗ-ийн 24-р тогтоол	

3. АУДИТЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ

3.1. Аж ахуй нэгжийн нэр

"Түшиг Интернэшнл" ХХК

3.2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар болон регистрийн дугаар

Регистрийн дугаар: 2714809

3.3. Аж ахуй нэгжийн хаяг, байршил

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15 дугаар хороолол, 65-21 тоот.

Утас: 99085051

4. АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ БОЛОН ГИШҮҮДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“Мон газар консалтинг” ХХК-ийн Байгаль орчны аудитын баг нь нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй, багийн ахлагч Ю.Дэлгэрмаа

Хүснэгт 2. Аудитын багийн гишүүдийн мэдээлэл

Багийн гишүүдийн нэр, зэрэг дэв	Мэргэжил	Багт гүйцэтгэх үүрэг
Ахлах аудитор, доктор Ю.Дэлгэрмаа	Газарзүй	Ногоон байгууламж
Аудитор, доктор, дэд профессор Ч.Сономдагва	Биологич	Агаарын чанар, хог хаягдлын менежмент
Аудитор, доктор Б.Даваажаргал	Хэрэглээний физик-экологи	Усны нөөц, чанар
Тус аудитор, магистрант Б.Баярцэцэг	Хүрээлэн буй орчны инженер	Биологийн нөхөн сэргээлт, ургамал хамгааллын менежмент

5. АУДИТ ХИЙХ ГАЗАР БОЛОН ЭХЛЭХ, ҮРГЭЛЖЛЭХ, ДУУСАХ ХУГАЦАА

5.1. Аудит хийх газар

“Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн талбай нь нийт 28.07 га бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 310 км, Бор-Өндөр өртөөнөөс 3.0 км-т тус тус байрлана.

5.2. Аудитын шалгуур

Байгаль орчны аудит гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг хэлнэ. Үндэсний хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, стандарт зэрэг нь тухайн төслийн хувьд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр дамжин хэрэгждэг. Үүний дагуу дараах чиглэлээр энэхүү байгаль орчны аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Агаар орчны аудит
2. Газар, түүний хэвлий, хөрс хамгааллын аудит
3. Усан орчны аудит
4. Биологийн олон янз байдлын аудит
5. Хог хаягдлын менежментийн аудит

6. АГААР ОРЧНЫ АУДИТ

6.1. Аудитын зорилго

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн агаар орчны чанар, агаар мандал дахь хийн ялгаруулалтын менежментийн чиглэлд байгаль орчны аудит хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ үл нийцсэн шалгуурт мэргэжлийн зөвлөмж боловсруулах зорилготой.

6.2. Аудитын хамрах хүрээ

Цаг хугацааны хувьд:

Тус төслийн 2021, 2022 оны үйл ажиллагаанд байгаль орчны аудитын ажлыг гүйцэтгэнэ.

Оронзайн хувьд:

Агаарын чанарт нөлөөлөл үзүүлж бохирдуулах эх үүсвэр нь төслийн үйл ажиллагаанд ашиглах тээврийн хэрэгсэл, ахуйн гаралтай хог хаягдал, дотоод тээвэрлэлтээс үүсэх тоосжилт зэрэг болно.

Хууль тогтоомжийн хүрээнд:

Хууль эрхзүйн баримт бичиг	Батлагдсан огноо	Шийдвэрийн дугаар	Хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон огноо
Төрийн бодлого, үндэсний хөтөлбөр			
Алсын хараа 2050 баримт бичиг	2020.05.13	МУИХ-ын 52 тоот	
Шинэ сэргэлтийн бодлого	2021.12.30	МУИХ-ын 106 тоот	
Монгол улсын хууль			
Агаарын тухай хууль	2012.05.17		2018.01.12
Агаарын төлбөрын тухай хууль	2010.06.24		2018.01.13
Ариун цэврийн тухай хууль	2016.02.04		2018.11.15
Монгол улсын дүрэм, журам			
Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах, эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах заавар	2014.05.19	БОНХ-ын сайдын А-181	
Стандарт			
Агаарын чанар, ерөнхий шаардлага (MNS 4585:2016)	2016.06.23	СҮЗ-ийн 37-р тогтоол	
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Хөдөлмөрийн эрүүл ахуй, Ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага-MNS 4990:2015	2015.09.24	СҮЗ-ийн 32-р тогтоол	

6.3. Аудитын шалгуур

Дээр дурдсан хууль тогтоомжийн хүрээнд 9 шалгуур үзүүлэлтээр агаар орчны аудитыг гүйцэтгэв. Нийт 9 шалгуур үзүүлэлт нь бүгд үндэсний хууль тогтоомж, дүрэм журамд тусгалаа олсон байна.

6.4. Баталгаажсан нотолгоо

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгох бөгөөд нийт 11 нотолгоог аудитын явцад цуглуулав. Үүнээс бичиг баримтын судалгааны явцад 7, газар дээрх аудитын явцад 4 нотолгоог бүрдүүлсэн. Нийт нотолгоог ангилан авч үзвэл:

~ Тэмдэглэл	... ширхэг
~ Баримт бичиг	7 ширхэг
~ Дуут бичлэг	... ширхэг
~ Дүрс бичлэг	... ширхэг
~ Асуулгын хуудас	... ширхэг
~ Ярилцлага	... ширхэг
~ Байршил	... ширхэг
~ Фото зураг	3 ширхэг
~ Лабораторийн шинжилгээ	1 ширхэг
~ Судалгааны үр дүн	... ширхэг багтана.

6.5. Аудитын үнэлэмж:

Нийт 9 шалгуурыг 11 нотолгоон дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

~ Нийцэл	6
~ Тодорхойгүй	...
~ Хугацаа болоогүй	2
~ Үл нийцэл	1

6.6. Үл нийцлийн эрсдэл:

Агаар орчны аудитаар дараах 1 үл нийцэл илэрсэн болно. Үл нийцлийг хэрэгжүүлэхгүй нөхцөлд үүсэх эрсдэлийг үр дагаварт суурилсан эрсдэлийн матрицын аргаар үнэлэсэн болно.

		Байгаль орчны хохирол үүсэх магадлал		
		Гарцаагүй	Боломжтой	Боломж бага
Байгаль орчны нөлөөллийн түвшин	Их			
	Дунд			
	Бага	AM 4		

Дээрх үр дүнгээс үзэхэд 1 үл нийцэл нь эрсдэл дунд ангилалд хамаарч байна. Эрсдэлийн түвшин бүрээс хамааруулан дараах зөвлөмжийг өгч байна.

6.7. Зөвлөмж:

Зөвлөмж АМ4: Агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын мэдээ тайланг мэргэжлийн хяналтын орон нутаг дахь салбарт гаргаж өгөх

6.8. Аудитын дүгнэлт:

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Төв аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн агаар орчны чанар, агаар мандал дахь хийн ялгаруулалтын менежментийн чиглэлд төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, үндэсний хууль тогтоомж, холбогдох дүрэм журам, аргачлал, стандартын хүрээнд нийцлийн болон гүйцэтгэлийн байгаль орчны аудит хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ үл нийцсэн шалгуурт мэргэжлийн зөвлөмж боловсрууллаа.

- “Түшиг Интернэшнл” ХХК -ийн “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн үйл ажиллагаа нь дээр дурьдсан хууль эрхзүйн баримт бичигт нийцэл 91.6 хувь, үл нийцэл нь 8.4 хувьтай байна.
- Үл нийцлээр үнэлэгдсэн АМ4 шалгуурын үл нийцэл нь баримт бичгийн шинжтэй буюу орон нутаг дахь агаарын чанарын мэргэжлийн албанд бохирдлын эх үүсвэрийн холбогдог мэдээ тайланг гаргаж өгч байхтай холбоотой.
- “Түшиг Интернэшнл” ХХК-ийн дээрх үл нийцэл болон тодорхойгүйгээр үнэлэгдсэн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг биелүүлэх зайлшгүй шаардлагатай.

Хүснэгт 3. Агаар орчны аудитын нэгдсэн хүснэгт

№	Аудитын шалгуур үзүүлэлт	Эрхзүйн үндэслэл	Баримт нотолгоо	Үнэлэмж	Тайлбар, тэмдэглэл
Хууль эрхзүйн баримт бичиг					
A-1	Бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх.	БХТХ-31.7	Нотолгоо А-1	Н	Байгаль орчны мэргэжилтэн талбай дээр ажиллаж байна.
A-2	Агаарын бохирдлын томоохон эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох	АТХ-9.1.3		ХБ	Тус уурхай одоогоор томоохон суурин эх үүсвэр ашиглаагүй байна.
A-3	Аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналт, мониторинг явуулах	АТХ-9.1.4	Нотолгоо А-3-1 Нотолгоо А-3-2 Нотолгоо А-3-3	Н	
A-4	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ мэргэжлийн албаар дүгнэлт гаргуулан сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авах	АТХ -18.1		ХБ	Тус уурхай одоогоор томоохон суурин эх үүсвэр ашиглаагүй байна.
A-5	Аж ахуйн нэгж, байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг зохих журмын дагуу мэргэжлийн хяналтын албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх	АТХ -9.1.5; БОАЖЯ-А/222		ҮН	Агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын тайланг БОАЖЯ-А/222 журмын дагуу боловсруулж сумын мэргэжлийн хяналтын нэгж эсвэл байгаль орчны албанд гаргаж өгөх

“Түшиг интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2” жоншны ордыг ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан

A-6	Төлбөр төлөгч нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн төлбөрийг жилд нэг удаа тухайн жилийн 6 сарын 01 өдрөөс өмнө харьяалах татварын албанд төлөх бөгөөд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн үзлэгийн гэрчилгээ нь агаарын бохирдлын төлбөр төлсөн тухай тэмдэглэх	АБТТХ- 9.3	Нотолгоо А-6	Н	
A-7	Агаарын бохирдлыг бууруулах техник, технологи, шингэрүүлсэн хийн түлш, бусад эх үүсвэрийг ашиглах	АТХ-9.1.9	Нотолгоо А-7	Н	
A-8	Агаарын бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэн агаарын бохирдлын төлбөр төлнө.	АТХ-29.1	Нотолгоо А-6	Н	
A-9	Хүн амын оршин суугаа орчны агаар нь эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангасан байна	ЭАТХ-4.3, 4.3.1, 4.3.2	Нотолгоо А-9	Н	

7. ГАЗАР, ТҮҮНИЙ ХЭВЛИЙ, ХӨРС ХАМГААЛЛЫН АУДИТ

7.1. Аудитын зорилго:

“Түшиг Интернэшнл” ХХК-ийн Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16-2 жоншны ордыг ашиглах” төслийн газар, түүний хэвлий, хөрс хамгааллын менежментийн чиглэлд байгаль орчны аудит хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ үл нийцсэн шалгуурт мэргэжлийн зөвлөмж боловсруулах зорилготой.

7.2. Аудитын хамрах хүрээ:

Цаг хугацааны хувьд:

Тус төслийн 2021, 2022 оны үйл ажиллагаанд байгаль орчны аудитын ажлыг гүйцэтгэнэ.

Оронзайн хувьд:

Далд уурхайн талбай, тэдгээрийг холбосон дотоод зам зэрэг нь хөрсний элэгдэл, эвдрэлийн хүчин зүйл, нөхөн сэргээлт, шимт хөрс хадгалалт, хамгаалал, шатах тослох материалын агуулах, засварын цех, ахуйн хог хаягдлын цэг зэрэг хөрсний бохирдлын эх үүсвэрийн хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал зэргийг хамарна.

Хууль тогтоомжийн хүрээнд:

Хууль эрхзүйн баримт бичиг	Батлагдсан огноо	Шийдвэрийн дугаар	Хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон огноо
Төрийн бодлого, үндэсний хөтөлбөр			
Алсын хараа 2050 баримт бичиг	2020.05.13	МУИХ-ын 52 тоот	
Шинэ сэргэлтийн бодлого	2021.12.30	МУИХ-ын 106 тоот	
Монгол улсын хууль			
Газрын тухай хууль	2002.06.07		2019.05.02
Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	2012.05.17		2015.12.04
Газрын хэвлийн тухай хууль	1988.11.29		2015.12.04
Стандарт			
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Хөдөлмөрийн эрүүл ахуй, Ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага-MNS 4990:2015	2015.09.24	СҮЗ-ийн 32-р тогтоол	
Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд-MNS 3298:1991	1991.04.25	УСШУТЗ-ийн 16-р тогтоол	
Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ-MNS 5850:2008	2008.05.30	СҮЗ-ийн 17-р тогтоол	

7.3. Аудитын шалгуур:

Дээр дурьдсан хууль тогтоомжийн хүрээнд 17 шалгуур үзүүлэлтээр газар, түүний хэвлий, хөрс хамгааллын аудитыг гүйцэтгэв.

7.4. Баталгаажсан нотолгоо:

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгох бөгөөд нийт 21 нотолгоог аудитын явцад цуглуулав. Үүнээс бичиг баримтын судалгааны явцад 14, газар дээрх аудитын явцад 7 нотолгоог бүрдүүлсэн. Нийт нотолгоог ангилан авч үзвэл:

~ Тэмдэглэл	... ширхэг
~ Баримт бичиг	14 ширхэг
~ Дуут бичлэг	... ширхэг
~ Дүрс бичлэг	... ширхэг
~ Асуулгын хуудас	... ширхэг
~ Ярилцлага	... ширхэг
~ Байршил	... ширхэг
~ Фото зураг	7 ширхэг
~ Лабораторийн шинжилгээ	... ширхэг
~ Судалгааны үр дүн	... ширхэг багтана.

7.5. Аудитын үнэлэмж

Нийт 17 шалгуурыг 21 нотолгоон дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

~ Нийцэл	16
~ Тодорхойгүй	
~ Хугацаа болоогүй	
~ Үл нийцэл	1

7.6. Зөвлөмж

Газар, түүний хэвлий, хөрсний чиглэлээр гүйцэтгэсэн аудитын явцад тус уурхайн хувьд энэ чиглэлд өмнө хийгдсэн ажлуудыг илүү сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг өгч байна.

Зөвлөмж ГГХ-3: Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор асгаралтыг бууруулах журам гаргаж дотоод үйл ажиллагаандаа мөрдөж байна. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Шатах тослох материалыг агааржуулалтын хавлагтай зориулалтын саванд хадгалах
2. Шатах тослох материалын хаягдал хадгалах талбайг хатуу хучилттай болгох
3. ШТМ болон түүний хаягдал асгарах үед авах арга хэмжээний үеийн багаж тоног төхөөрөмжийг боломжит цэгүүдэд байрлуулах, жил бүр шинэчилж байх.

